

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

2020 оны жилийн эцэс

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
1	1	Инновацийн тухай 2012-05-22 Дугаар 2012.07.05	17.1.12. Үндэсний инновацийн шагналын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.	Засгийн газрын 2018 оны 49 дүгээр тогтоолоор “Үндэсний инновацийн шагнал олгох журам”-ыг баталсан. Журмын зохицуулалтаар 2 жилд нэг удаа, “Шилдэг инновацийн бүтээгдэхүүн”, “Үйлчилгээний салбарын шилдэг инноваци” гэсэн 2 төрөлд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд үндэсний инновацийн шагналыг олгохоор журамласан. Тус журмын дагуу 2018 онд Шилдэг инновацийн бүтээгдэхүүний шагналыг Гарааны ветбиотек ХХК-ийн малын эктопаразитүүд болон хачиг шимэгчлэхээс урьдчилан сэргийлэх, эмчлэх зориулалтай бэлдмэл “Делтамон Пу-рон”, Үйлчилгээний салбарын шилдэг инновацийн шагналыг Айтүүлс ХХК-ний “Дата төвийн бүтээгдэхүүн, үйлчилгээ” тус тус хүртэж байсан бол 2020 онд Баргилтех ХХК-ийн “Эко барьцалдуулагч” бүтээгдэхүүнд “Шилдэг инновацийн бүтээгдэхүүн”, Ворлд плас дижитал ХХК-ийн “Ворлд плас аппликэйшн” бүтээгдэхүүнд	100%	100%	

				“Үйлчилгээний салбарын шилдэг инноваци”-ийн шагналыг олгосон.			
	2		6.1.13. Паркийн нутаг дэвсгэрт олгосон газар, төрийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, нутаг дэвсгэрт үйлчлэх хөнгөлөлт, урамшуулал, тэдгээрийн хэлбэр, хэмжээг тогтоох, паркийн үйл ажиллагаатай холбогдох дүрэм, журам баталж мөрдүүлэх. (6.1.Засгийн газар инновацийн үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	Их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын судалгаа шинжилгээ, инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, инновацийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх дэд бүтэц, орчныг бүрдүүлэх, импортыг орлох, экспортод чиглэсэн өндөр технологи, инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардагдах санхүүгийн олон талт эх үүсвэрээр хангах, инновацийн үйл ажиллагаанд тулгуурлан бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл байгуулах тухай” 19 дүгээр тогтоолоор инноваци, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиг үүрэг бүхий шинжлэх ухааны паркийн захиргааг байгуулсан. Тус захиргааны бүтэц, дүрэм, үйл ажиллагаатай холбоотой дүрэм журам (5)-ыг батлан хэрэгжүүлсэн. Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулахтай холбоотой бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Шинжлэх ухааны парк байгуулах ТЭЗУС-ыг хийлгэсэн. Шинжлэх ухааны паркийг байгуулах байршлыг тогтоох судалгааг хийж, МУ-ын 5 байршил(хамгийн боломжит байршил УБ Аэросити/-д байгуулах боломжтой гэсэн судалгааны үр дүн, дүгнэлт гаргасан.	100%	100%	
2	3	Боловсролын	39.12. 39.12.Төрийн өмчийн	Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий	100%	100%	

		тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2013-02-07 Дугаар 2013_05	ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.	боловсролын сургууль, цэцэрлэг өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, түүнийг зарцуулах, тайлагнах журмын төслийг боловсруулж, яамны цахим хуудсанд http://www.mecss.gov.mn/forum180109 байршуулж, олон нийтэд хэлэлцүүлсэн. Журамд “Төрийн болон орон нутгийн өмчийн” гэж хамрах хүрээг өргөжүүлэн оруулж, нэмэлт орлогод тооцох орлогууд, түүнийг зарцуулах зориулалт зэргийг салбарын онцлогийг харгалзан тусгаж, Сангийн яаманд хүргүүлсэн. Сангийн яам тусгайлан журам гаргах шаардлагагүй гэж үзэн Төсвийн тухай хуулийг баримтлан Сангийн сайдын тушаалаар улсын төсвийн бүх байгууллага дагаж мөрдөх нийтлэг журам гаргахаар шийдвэрлэсэн болно. Ингэснээр Монгол Улсын Төсвийн тухай хууль 47 дугаар зүйлийн 47.1 болон 47.1.5 дахь заалтын дагуу Сангийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 216 дугаар тушаал, 2019 оны 74 дүгээр тушаалаар шинэчилж “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг баталсан. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүд Сангийн сайдын баталсан энэхүү журмыг дагаж мөрдөж байна.			
3	4	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай 2013-02-07	8.15. Сургуулийн өмнөх боловсрол олгож байгаа байгууллагын нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог боловсролын нийгмийн	Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 9.9 дэх хэсэгт Хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгийн ердийн бүлгийн хүүхдүүдтэй хамт сургаж болох бөгөөд хөнгөн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хоёр хүртэл хүүхэд нэг бүлэгт	100%	100%	

		Дугаар 2013_06	хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.	байж болно гэж заасан. Цаашид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн цэцэрлэгт тэгш хамруулан сургах зорилтыг хэрэгжүүлэх, ХБХ-ний эрхийн конвенц, олон улсын чиг хандлагад нийцүүлэн нэг багшид ногдох хүүхдийн тоог заах шаардлагагүй болж байна. Энэ үзэл баримтлалыг Сургуулийн өмнөх, бага дунд боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусган боловсруулж байна. 2020-2021 оны хичээлийн жилд тусгай 5 цэцэрлэгийн 18 бүлэгт 204, ердийн цэцэрлэгт 952 хүүхэд, нийт 1156 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна.			
4	5	Бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2013-02-07 Дугаар 2013_07	13.8. Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа нэг багшид ногдох хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоог боловсролын, нийгмийн хамгааллын, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан "Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам батлах тухай" 2007 оны 307/91/237 дугаар тушаалаар "Анги дүүргэлтийг харах, сонсох эрхтний хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 8-12, оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн бүлэгт 10-15 хүүхэдтэй байхаар зохион байгуулна." гэж заасан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаалаар баталсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамран сургах журам"-д тухайн хүүхдийг оршин суугаа нутагт нь боловсролын үйлчилгээнд хамруулах талаар тусгасан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг өөрийн оршин суух газартаа хамт олонд түшиглэн	100%	100%	

			хөгжүүлэх үзэл баримтлалыг дэмжиж, тухайн суралцагчид хувьсах зардлыг 3 дахин нэмэгдүүлэн, 10.8 тэрбум төгрөгийг сургалтын байгууллагуудад олгосон байна. Дээрх зардлаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах орчин, тохирох хэрэглэгдэхүүнийг шийдвэрлэн ажиллаж байна. 2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын тусгай сургуульд 1709 хүүхдэд 328 багш ажиллаж байгаа нь 1 багшид дунджаар 5.2 хүүхэд, харин ердийн хэв шинжтэй сургуулийн 3861 хүүхэд 3033 бүлэгт суралцаж, нэг багшид 1.3 хүүхэд ноогдож байгаа нь олон улсын жишигт нийцэж байна.			
	6	13.9. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн боловсролын үнэлгээний журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам” батлагдсан. Журмын 3.15-д "Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ. Шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулна", 3.16-д "Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ. Суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн, энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс шийдвэрлэнэ" гэж тус тус тусгасан. Дээрх	100%	100%	

				үнэлгээний журмаар ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж буй сурагчдыг үнэлж байна.			
5	7	Хууль тогтоомжийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2015-05-29 Дугаар 2017.01.01	49.1. Улсын Их Хурал, Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлж, холбогдох бүтцийн нэгжийг ажиллуулна.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 51 дугаар тогтоолоор Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаар батлагдсан. Үүнд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газартай байхаар туссан ба 7 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.	100%	100%	
	8		52.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг Улсын Их Хурал, Засгийн газар жилд нэг удаа тогтмол хэлэлцэж хууль тогтоомжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хууль тогтоомжид зохих нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийг хооронд нь уялдуулах, хууль тогтоомжийг системчлэн кодификаци хийх, шинээр хууль тогтоомжийн төсөл боловсруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” батлагдсан. 2020 оны 206 дугаар тогтоолоор уг журмыг шинэчлэн баталсан. Боловсрол, шинжлэх ухааны яам нь дээрх журмын хүрээнд салбарын хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хагас жил, бүтэн жилээр тайлагнаж, ЗГХЭГ-т хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байна. Боловсролын багц хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулж, хуулийн төслийн хэлэлцүүлгийг улс орон даяар амжилттай зохион байгуулан төрийн захиргааны төв байгууллагуудаас саналыг нь авч тусган, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэл ажлыг бүрэн ханган ажилласан болно. Тус хуулийн төслийг боловсруулахдаа салбарын хууль тогтоомжийн уялдааг хангаж, боловсролын системийг бүхэлд нь хамарсан шинэчлэлийг хийх зарчмыг иш үндэс болгон, Монгол улсын	100%	100%	

			хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн боловсруулж, боловсролын харилцаанд оролцогч талуудын санал бодлыг тусгаж ажилласан болно.			
	9	49.3.. Засгийн газраас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.	Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хэрэгжүүлэн, хагас, бүтэн жилээр хугацаанд нь Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийг хангуулж ажиллах чиглэлээр холбогдох арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%	100%	
	10	49.5.. Улсын Их Хурал, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний бүтцийн нэгж нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн эерэг, сөрөг үр дагаврын талаарх хяналт шинжилгээний дүнг хууль санаачлагчид тогтмол мэдээлнэ.	Боловсрол, шинжлэх ухааны яамны эрхлэх асуудалд хамаарахгүй тул хяналтаас хасах.	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	30%	
	11	49.6.. Энэ хуулийн 49.5-д заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний дүнд үндэслэн хууль	2019 оны жилийн эцэс, 2020 оны эхний хагас жилийн Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн үр дагаврын үнэлгээ хийгдээгүй болно.	100%	30%	

			тогтоомжийн зорилгын түвшин хангалтгүй, хууль тогтоомжийн үзэл баримтлалд заасан үр дүнд хүрч чадахгүй тохиолдолд хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийнэ.				
	12		49.7.. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг журамд заасны дагуу төрийн захиргааны асуудал хариуцсан нэгжээс нэгтгүүлэн авч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар хэрэгжүүлэн ажиллаж байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх явцад хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжилтийн явц удаашралтай байгаа асуудлаар хариуцсан бодлогын нэгжид зөвлөмж өгч биелэлтийг хангуулан ажиллахад анхаарч ажиллаж байна. Түүнчлэн хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой тус яаманд ирүүлсэн зөвлөмж, аудитын дүгнэлттэй холбоотой асуудлыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	100%	30%	
6	13	Хүүхэд харах үйлчилгээний тухай 2015-07-02 Дугаар 2016.01.01	10.2. Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам, эцэг, эх, асран хамгаалагчаас төлөх төлбөрийн дээд хэмжээг	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн А/409 дугаар тушаалаар батлагдсан Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам-ыг батлуулсан. Уг журмын 7-д хүүхэд харах үйлчилгээнд эцэг, эх, асран хамгаалагчаас төлөх төлбөрийн дээд хэмжээг, 7.1-д Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхэд харах үйлчилгээ эрхлэгчтэй	100%	100%	

		Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно. /Энэ хэсгийг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/	харилцан тохиролцсоны үндсэн дээр хүүхэд харах үйлчилгээний орчныг сайжруулах, илүү цагаар ажиллах, хүүхэд хөгжүүлэх сургалтын тусгай хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт төлбөр төлж болохоор журамлагдсан. Мөн уг журмын 7.2-т Эцэг эх, асран хамгаалагчийн сард төлөх нэмэлт төлбөрийн дээд хэмжээ нь улсын төсвөөс олгож буй хоолны болон нормативд зардлын нийлбэрийн 60 хувиас хэтрэхгүй байхаар тусгайлан заалтыг тусгасан болно.			
	14	6.7.. Хүүхэд харах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага, стандартыг Засгийн газар батална.	Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 36 дугаар тогтоолоор “Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” баталж, мөрдөгдөж байна.	100%	100%	
	15	6.5.. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан нэг хүүхэд харагчид оногдох хүүхдийн тоо таваас илүүгүй байх бөгөөд хүүхдийн насны ялгааг харгалзан Засгийн газар тогтооно.	Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 5.1. “хоёр наснаас ерөнхий боловсролын сургуульд элсэх хүртэлх нас”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг нас харгалзахгүйгээр” хүүхэд харах үйлчилгээнд тус тус хамруулна. 2020-2021 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 231 хүүхэд харах төвд 2827 хүүхэд хамрагдсан. Үүнд: 1. Ердийн хөгжилтэй 2370 хүүхэд 2. Хөгжлийн бэрхшээлтэй 113 хүүхэд Хилчдийн 165 хүүхэд байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 09 сарын 15-ны өдрийн А/62 дугаартай “хүүхэд харах үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” тушаал батлагдсан.	100%	100%	
	16	10.1.. Хүүхэд харах үйлчилгээний бодлого, төлөвлөлт, санхүүжилт,	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 6 сарын 26 өдрийн А/409 тоот тушаалаар хүүхэд харах үйлчилгээг	100%	100%	

			удирдлага, мэдээлэл, хяналт-шинжилгээ, зохицуулалтыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа агентлаг, хэлтэс хариуцан хэрэгжүүлнэ. /Энэ хэсгийг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/	зохион байгуулах, хяналт тавих журам батлагдсан. ес. хүүхэд харах үйлчилгээний хяналт 9.1.Аймаг, нийслэлийн Боловсролын газар, мэргэжлийн хяналтын байгууллага, баг, хороо, сум, дүүргийн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийн хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилтэд хамтран хяналт тавьж, "Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам"-ын 5.5-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. гэж тусгасан.			
	17		10.4. Хүүхэд харагчийг бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. /Энэ хэсгийг 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын 2018 оны 6 сарын 26 өдрийн А/409 тоот тушаалаар батлагдсан Хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам-ын 5-д хүүхэд харагч бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалт 5.1.Хүүхэд харагч бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтыг аймаг /дүүрэг/-ийн боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Сургуулийн өмнөх боловсролын сургуультай хамтран 3 үе шаттай зохион байгуулна. 5.1.1.Хүүхэд харагчийг бэлтгэх анхан шатны сургалт 3 кредит цаг, гэрчилгээний хүчинтэй хугацаа 1,5 жил байна. 5.1.2.Хүүхэд харагчийг мэргэжил дээшлүүлэх хоёр дахь шатны сургалт 3 кредит цаг, гэрчилгээний хүчинтэй хугацаа 2 жил байна. 5.1.3.Хүүхэд харагчийг мэргэжил дээшлүүлэх гурав дахь шатны сургалт 3 кредит цаг, гэрчилгээний хүчинтэй хугацаа 3 жил байна. гэж заасан.	100%	100%	
7	18	Хөгжлийн	12.2.. Монгол дохионы	Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын	70%	70%	

		бэрхшээлтэй хүний эрхийн тухай 2016-02-05 Дугаар 16-04	хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журмыг боловсролын болон хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх журам"-ын төслийг боловсруулсан. Монгол дохионы хэлний хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа эрхлэх, үйлчилгээ үзүүлэх харилцааг зохицуулж, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний дохионы хэлийг хэлмэрчилж, орчуулах үйл ажиллагаанд мөрдлөг болгох зорилгоор энэхүү журмыг боловсруулсан хэдий ч Монгол Улсын үндэсний ажил мэргэжлийн ангилал болон тодорхойлолтод дохионы хэлний хэлмэрч, орчуулагч гэсэн мэргэжил байхгүй тул батлагдаагүй болно.			
	19		14.5.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах, хөгжүүлэх, бүх шатны боловсрол олгох үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөг Засгийн газар батална.	"Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах арга, аргачлал" батлагдсан. Монгол дохионы хэлмэрч, орчуулгын үйл ажиллагаа явуулах журам"-ыг боловсруулсан. 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн "Монгол брайль үсгийн стандарт"-ыг Эрүүл мэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээний стандартчилал техникийн хороогоор хэлэлцүүлэн баталсан. 2019-2020 оны хичээлийн жилд Дэлхийн банкны Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд тэгш хамруулан суралцуулах боловсролын сургагч багшийг үндэсний хэмжээнд бэлтгэх ажлыг зохион байгуулахаар санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэн зохих бэлтгэлийг ханган ажилласан. 2018 оны БСШУС-ын сайдын А/491 тоот тушаалаар "Оюуны, сонсголын, харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, А/490 тоот тушаалаар " Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгал" хичээлийн	100%	100%	

				хөтөлбөрийг боловсруулсан. 2020 онд “Хүүхдийн хэл ярианы хөгжил” жишиг хөтөлбөрийг боловсруулан хөтөлбөр хэрэгжиж байна.			
	20		15.8.. Энэ хуулийн 15.6-д заасан сургалтын зардлын хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоолын 5 дугаар заалтаар “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 7-ны өдрийн 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын “4.1.2. бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагч эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрийн суралцагч”-д сургалтын төлбөрийн буцалгүй тусламж олгохоор болсон. Түүнчлэн тус тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн зээл олгох журам”-ыг шинэчлэн баталсан.	100%	100%	
	21		15.2.. Бүх шатны сургалтын байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны "Журам батлах тухай" А/184 дүгээр тушаалаар “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам” батлагдсан. Энэхүү журмаар бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн суралцах орчин бүрдүүлэх харилцааг зохицуулсан. Журмыг	100%	100%	

				батлан хэрэгжүүлснээр хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучууд бүх шатны сургалтын байгууллагад суралцах тэгш боломж бүрдэх юм.			
	22		15.3.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол олгох сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	2018 оны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/491 дүгээр тушаалаар “Оюуны, сонсголын, харааны бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, А/490 дүгээр тушаалаар “Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгал” хичээлийн хөтөлбөрийг боловсруулсан. 2020 онд Хэл ярианы бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэхэд чиглэсэн “Хэл ярианы хөгжил” хичээлийн сургалтын жишиг хөтөлбөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны “Жишиг хөтөлбөр батлах тухай” А/305 дугаар тушаалаар батлагдсан. "COVID-19"-ийн нөхцөл байдлаас шалтгаалан “Хэл ярианы хөгжил” засан сайжруулах ганцаарчилсан хичээлийн сургалтын жишиг хөтөлбөрийг хэрэгжүүлэх 15 видео хичээлийг боловсруулан DVD хэлбэрээр аймаг, нийслэлийн БСУГ-ын мэргэжилтнүүдээр дамжуулан үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлж байна.	100%	100%	
	23		15.9.. Энэ хуулийн 15.7-д заасан ном, сурах бичиг, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслийн жагсаалт, зардлын хэмжээ, олгох журмыг боловсрол болон хөгжлийн бэрхшээлтэй	“Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөгжлийн түвшнийг тодорхойлох, багшлах арга зүйн хэрэглэгдэхүүн” /2019 он/, “Суралцахуйн хоцрогдолтой, зан үйлийн эмгэгтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх арга зүй, хэрэглэгдэхүүн” /2019 он/, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан “Дохионы хэлээр харилцаж сурцгаая” багц карт /2019	100%	100%	

			хүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	он/, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үгийн нөөц нэмэгдүүлэх зорилгоор хэл ярианы дутмагшилтай хүүхдэд зориулсан “Зурган таних тэмдгийн эмхэтгэл”-ийг 144.9 сая төгрөгөөр 29.700 ширхгийг тус тус хэвлүүлэн бүх сургууль, насан туршийн боловсролын төвүүдэд хүргүүлэн улсын хэмжээнд сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны "Журам батлах тухай" А/292 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар "Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим"-д байвал зохих хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслийн жагсаалтыг баталсан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/184 дүгээр тушаалаар “Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын орчныг бүрдүүлэх журам” батлагдсан.			
8	24	БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 2016-04-14 Дугаар 16-04	“9.5.. Гадаад улсын боловсролын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх, багц цаг харилцан тооцох асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.”	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/156 дугаар тушаалаар “Суурь, бүрэн дунд боловсрол эзэмшигчдэд боловсролын баримт бичиг олгох, дүйцүүлэх журам”-ыг батлан хэрэгжүүлж байна. Энэхүү журмаар гадаад улсад суурь, бүрэн дунд боловсрол эзэмшсэн иргэний баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэн тооцох асуудлыг зохицуулж байгаа бөгөөд одоогийн байдлаар 500 гаруй иргэний асуудлыг шийдвэрлээд байна. Боловсролын ерөнхий хуулийн төсөлд "Гадаад улсын боловсролын баримт бичгийг Монгол Улсын боловсролын баримт бичигтэй дүйцүүлэх, багц цаг харилцан хүлээн зөвшөөрч,	100%	100%	

			дүйцүүлэх асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу шийдвэрлэнэ.", "Олон улс гадаад орны сургалтын хөтөлбөрөөс Монгол Улсын сургалтын байгууллагад шилжин суралцах тохиолдолд сургалтын баримт бичгийг дүйцүүлэх, багц цаг тооцох асуудлыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан журмын дагуу шийдвэрлэнэ." гэсэн заалт нэмж оруулахаар тусгаад байна. Мөн Оюутан элсүүлэх журамд энэ талаар нэмэлт оруулахаар төсөлд тусгаад байна. ОХУ-д 5 жилээс дээш мэргэжилтнээр суралцсан төгсөгчдийн боловсролын баримт бичгийн магистрын зэрэгтэй дүйцүүлэх тухай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/229 дүгээр тушаал гарсны дагуу иргэдийн хүсэлтийг хүлээн авч одоогийн байдлаар 100 гаруй хүний асуудлыг шийдвэрлэсэн. Монгол Улс нь ОХУ, БНХАУ, Турк, Австри, Куба, Украин, Лаос, Польш улстай боловсролын баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай баримт бичгүүдийг Засгийн газрын түвшинд байгуулсан байдаг.			
	25	18.5.. Энэ хуулийн 3.1.19-т заасан үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална."	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Нийтлэг шаардлага батлах тухай" А/152 дугаар тушаалаар "Өдөр өнжүүлэх үйлчилгээ эрхлэхэд тавих нийтлэг шаардлага"-ыг баталсан.	100%	100%	

9	26	ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 2016-04-14 Дугаар 16-04	4.5.. Дээд боловсролын зэрэг олгодог онолын мэдлэг, ур чадвар, дадал бүхий үйлдвэрийн инженер, технологичийг бэлтгэх технологийн коллеж байх бөгөөд технологийн коллежийн хөтөлбөрийн агуулга, багц цагийн хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.”	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн “Нийтлэг шаардлага батлах тухай” А/177 дугаар тушаалаар “Үйлдвэрийн инженер, технологичийг бэлтгэх технологийн коллежийн сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ыг баталсан. Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/52 дугаар тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх дипломын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/ индекс”-ийг шинэчлэн баталсан.	100%	100%	
10	27	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ 2016-04-14 Дугаар 16-04	15.4.. Төрийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хувийг эцэг, эх, асран хамгаалагчаас, Нийгмийн халамжийн тухай хуулийн 20.2-т заасан хүүхдийн хоолны зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.	2020-2024 он хүртэл цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын нормативыг үе шаттайгаар нэмж 2 дахин нэмэгдүүлэх тооцоо судалгааг хийгээд байна. Мөн “Сургуулийн өмнөх боловсролын тухай” хуулийн 15.4-т заасныг үндэслэн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын тодорхой хувь хэмжээг эцэг эх, асран хамгаалагчаас гаргуулах эрхзүйн орчныг 2021 онд бүрдүүлэхээр төлөвлөж байна. Цаашид төсвийн боломж болон бусад эх үүсвэртэй уялдуулан 2022 оноос хоолны зардлыг 25-30% нэмэгдүүлэх, улмаар 2024 оноос хоолны зардлыг төр 50 хувь, эцэг, эх асран хамгаалагч 50 хувийг төлж хамтран хариуцлага хүлээх зарчимд шилжих, санхүүгийн нөөцийг төлөвлөн хэрэгжүүлэхээр ажиллаж байна. 2020 онд цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд төрөөс 90.2 тэрбум төгрөг зарцуулсан.	100%	100%	

	28		“7.1.. Хүүхдийн чадвар, чадамж, хөгжлийн ахицыг үнэлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”	“Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж буй хүүхдийн хөгжил болон сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэх журам”-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 280 дугаар тушаалаар баталсан. Уг журмын онцлог нь 1. Өмчийн бүх хэлбэрийн хүүхдийн цэцэрлэгийн үндсэн болон хувилбарт сургалтад хамрагдаж буй хүүхдийн хөгжилд гарч буй ахиц өөрчлөлтийг илрүүлснээр хүүхдийн хөгжлийн талаар бодит мэдээлэлтэй болох, дүн шинжилгээ хийх, хүүхдийн хөгжлийн тухай бодит мэдээллийг эцэг эхэд мэдээлэх зэрэгт үнэлгээний үр дүнг ашиглах ач холбогдолтой юм. 2. Үнэлгээний үр дүнд үндэслэн хүүхдийн хөгжлийг дэмжих, сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлэлт өгөх, цэцэрлэгийн үндсэн болон хувилбарт сургалтын чанар, багшийн арга зүй, ур чадварыг сайжруулахад чиглэгдэж байна. Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээг үндэсний түвшинд, тодорхой хугацааны давтамжтай хийснээр сургуулийн өмнөх боловсролын чанар, үр дүнг үндэслэн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгох, боловсролд оруулж буй хөрөнгө оруулалтын үр ашгийг тооцож, цаашдын чиглэлийг тодорхойлоход ач холбогдолтой юм.	100%	100%	
11	29	Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай 2016-09-01 Дугаар 2016.09.01	9.5.. Гадаадын цэргийн сургууль, академи, дамжаанд суралцагчийг сонгон шалгаруулах, сургалтын тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг олгох	Батлан хамгаалахын яам хариуцах тул хяналтаас хасах	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	

			журмыг Засгийн газар батална.				
12	30	Олон улсын гэрээний тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-01 Дугаар 2017.01.01	9.1.. Хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах саналыг тухайн гэрээний эцэслэн тохиролцсон, эсхүл үзэглэсэн төсөл, эсхүл баталсан буюу жинхэлсэн эх бичвэрийн хуулбар, боломжтой бол баталгаат хуулбар, шаардлагатай бол түүний орчуулгын хамт уг олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр холбогдох журмын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.	Хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах саналыг уг олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг Боловсрол, шинжлэх ухааны яамны Гадаад харилцаа хамтын ажиллагааны газар 2020 онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй болно.	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	
	31		24.2.. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан бол холбогдох	Боловсрол, шинжлэх ухааны яамны Гадаад харилцаа хамтын ажиллагааны газар 2020 онд олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулаагүй .	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	

		байгууллагатай хамтран биелүүлнэ.				
	32	24.5.. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийг гэрээний нөгөө тал, эсхүл бусад тал хэрхэн биелүүлж байгаа, монголын талын эрхийг хэрхэн хангаж байгаад тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.	Гадаад харилцааны яамны чиг үүрэгт хамаарах асуудал тул хяналтаас хасах		Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй
	33	25.1.. Монгол Улс олон улсын гэрээний дагуу тухайн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан гаргах үүрэг хүлээсэн бол тайланг уг олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан бол холбогдох төрийн байгууллагатай хамтран боловсруулна.	Гадаад харилцааны яамны чиг үүрэгт хамаарах асуудал тул хяналтаас хасах		Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй
	34	25.3.. Энэ зүйлийн 25.1, 25.2-т заасны дагуу боловсруулсан тайланг төрийн захиргааны төв	Гадаад харилцааны яамны чиг үүрэгт хамаарах асуудал тул хяналтаас хасах		Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй

		байгууллага гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ. /25.1.Монгол Улс олон улсын гэрээний дагуу тухайн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан гаргах үүрэг хүлээсэн бол тайланг уг олон улсын гэрээгээр зохицуулах асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн олон улсын гэрээгээр салбар хоорондын харилцааг зохицуулсан бол холбогдох төрийн байгууллагатай хамтран боловсруулна./ /25.2.Тайлан боловсруулах үүрэг бүхий төрийн захиргааны төв байгууллага тайланг түүнд тавигдах шаардлагад нийцүүлэн хугацаанд нь боловсруулж, шаардлагатай хэлээр орчуулах үүрэгтэй./				
	35	34.2.. Энэ зүйлийн 34.1-д заасан хуулийн төслийг тухайн олон улсын гэрээг	Гадаад харилцааны яамны чиг үүрэгт хамаарах асуудал тул хяналтаас хасах	Хугацаа болоогүй / үнэлэх	Хугацаа болоогүй / үнэлэх	

			хариуцан байгуулж байгаа төрийн захиргааны төв байгууллага холбогдох хууль тогтоомжид заасан журмын дагуу боловсруулах үүрэгтэй. /34.1.Олон улсын гэрээ байгуулснаар, түүнд нэгдэн орсноор, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хүчин төгөлдөр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай бол тухайн олон улсын гэрээг соёрхон батлах, батлах саналыг өргөн мэдүүлэхдээ тухайн хуулийн төслийг хамт өргөн мэдүүлнэ./		боломжгүй	боломжгүй	
13	36	Хог хаягдлын тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-05-12 Дугаар 2017.05.12	8.4.2.. 8.4.Хог хаягдлын талаар боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.4.2. Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын сургалтын хөтөлбөрт хог хаягдлын талаархи боловсролын агуулгыг тусгах;	Сургуулийн өмнөх боловсрол: Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2018 оны “Сургалтын хөтөлбөр батлах тухай” А/181 дүгээр тушаалаар “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр”-т хог хаягдлын талаарх агуулгыг тусган хэрэгжүүлж байна. Үүнд: Хог хаяхгүй байх, хог хаягдлаа зориулалтын саванд ялгаж хийж хэвших, гол, усанд хог хийхгүй байхыг мэдэх, цаас, усыг гамтай хэрэглэж хэвших зэрэг агуулгууд тусгагдсан. Бага, дунд боловсрол: Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/220 дугаар тушаалаар баталсан дунд ангийн хими, газар зүй, дизайн технологийн сургалтын хөтөлбөрт дараах байдлаар тусгагдсан. Химийн сургалтын хөтөлбөрт: •	100%	100%	

				Бохирдол. Бохирдол ухагдахууныг томъёолж, ус ахуйн хог хаягдлаар бохирдох шалтгааныг олж тайлбарлах, ахуйн нөхцөлд бохирдлоос сэргийлэх, түүнд оруулах хувь нэмрээ тодорхойлж чаддаг болно. Газар зүйн сургалтын хөтөлбөрт: • Байгаль хамгаалал. Байгаль хамгаалах уламжлалт зан үйл, тусгай хамгаалалттай газар нутгийн талаар мэдээлэл цуглуулан боловсруулж, тархалтыг зурагт тэмдэглэн ач холбогдлыг дүгнэж, орон нутагтаа тулгарч буй байгаль орчны тулгамдсан асуудал хог хаягдлыг хэрхэн шийдвэрлэх талаар саналаа боловсруулах, Дизайн технологийн сургалтын хөтөлбөрт: • Хэрэглээнээс гарсан хог хаягдлыг дахин боловсруулахтай холбоотой баримт мэдээллийг судлах, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар хаягдал материалыг ашиглан хэрэгцээт зүйл бүтээх • Технологи ажилбарын үед гарсан хог хаягдлыг ангилах дахин ашиглах боломжтойг ялгах, ажлын байрны эмх цэгц, аюулгүй байдлыг ханган ажиллах, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/277 дугаар тушаалаар баталсан ахлах ангийн химийн сургалтын хөтөлбөрт дараах байдлаар тусгагдсан. • Халдварт өвчний тархалтыг зохицуулахад хоол хүнсний ариутгал, хувийн ариун цэвэр, бохир ус болон хог хаягдлын цэвэрлэгээ ямар ач холбогдолтойг хэлэлцэх.			
14	37	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай 2017-05-18	8.2.. "Энэ хуулийн 8.1.1-д заасан хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн	Дунд, ахлах ангийн сургалтын цөм хөтөлбөрүүд бүхэлдээ суралцагчдыг хөгжүүлэх зорилготой. Тэдгээрийн дотроос дараах сургалтын хөтөлбөрүүдээр суралцагчдад амьдрах ухааны болон ажил	100%	100%	

		Дугаар 2017.05.18	захиргааны төв байгууллага батална. /8.1.1-д ерөнхий боловсролын болон их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, насан туршийн боловсролын төв, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт хувь хүний хөгжлийг дэмжих, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх хичээлийн агуулгыг тусгах/”	мэргэжлийн чиг баримжаа олгох мэдлэг чадварыг эзэмшүүлж байна. Үүнд: 1. Дунд ангийн хувьд: Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны А/302 дугаар тушаалаар баталсан “Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа”, “Иргэний боловсрол”-ын сургалтын хөтөлбөрөөр амьдрах ухааны чадваруудыг болон ажил мэргэжлийг танин мэдэх, ажил мэргэжлээ зөв сонгох мэдлэг, чадвар эзэмшүүлж байна. 8, 9 дүгээр ангид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын модуль, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох гарын авлага, “Суралцах төлөвлөгөө” боловсруулан IX ангид тус бүр 45,500 ширхэг, VIII ангид тус бүр 43,000 хувь хэвлэж, ерөнхий боловсролын нийт сургуульд түгээн хэрэгжүүлж эхэллээ. 8, 9 дүгээр ангийн суралцагчдын мэргэжил сонголтын талаарх судалгаа нэгтгэн дүгнэлээ. Мөн судалгааны үр дүнд тулгуурлан сонгон суралцах хичээлийн орчин бүрдүүлэх тоног төхөөрөмж нийлүүлэх шаардлагатай сургуулиудын жагсаалт гаргалаа. 2. Ахлах ангийн хувьд: Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2016 оны А/275 дугаар тушаалаар баталсан бизнес судлал, технологи, урлаг, спорт, эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт суралцагчдад амьдрах чадварууд эзэмшүүлж байна. Мөн ажил мэргэжлийн талаарх мэдлэг чадвар олгож байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Нийтлэг шаардлага батлах тухай” 2014 оны А/174 дүгээр тушаалын Ерөнхий суурийн хичээлийн чиглэлийн “Биеийн тамир, эрүүл ахуйн” хэсэгт “Бие бялдраа хөгжүүлэх, эрүүл амьдрах ухаанд суралцах, эрсдэл гамшгийн үед аюулгүй байдлаа хангах, анхан			
--	--	-------------------	--	---	--	--	--

				шатны тусламж үзүүлэх чадвар эзэмшүүлэх” гэж, “Иргэний боловсрол”-ын хэсэгт “Монголын түүх, соёл, улс төр, эдийн засаг, эрх зүй, хүний үндсэн эрх, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, багаар ажиллах ур чадварыг хөгжүүлэх” гэж тус тус заасны дагуу их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрт агуулгыг оруулан мөрдөж байгаа нь хуульд нийцсэн.			
15	38	Багшийн хөгжлийг дэмжих тухай 2018-06-27 Дугаар 2019.01.01	6.2.. Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг Засгийн газар батална.	АХБ-ны төслийн хүрээнд багшийн ажлыг үнэлэх үнэлгээний шалгуур боловсруулах ажлын хэсэг байгуулан ажилласан. Чадварлаг багш арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан 2 удаа хэлэлцүүлсний эцэст Засгийн газрын хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэгдэж, арга хэмжээг хэрэгжүүлэх Боловсрол, шинжлэх ухааны сайдын шийдвэр гарахад бэлэн болоод байна. Дэлхий нийтийг хамарсан цар тахал (COVID-19)-ын халдварын дэгдэлт ихэссэнтэй холбогдуулан улс орнуудад танхимын сургалтыг зогсоож, хөл хорио, хөдөлгөөний хязгаарлалт тогтоосон шалтгааны улмаас нэгдсэн нээлттэй хэлэлцүүлэг хийх боломжгүй болсон. /Засгийн газрын тогтоолоор баталсан/	100%	100%	
	39		7.5.. Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Багшийн хөгжлийн төвд тавигдах шаардлага, ажиллах үлгэрчилсэн журмын төсөл бүрэн боловсрогдсон боловч хөгжлийн төвд тавигдах тоног төхөөрөмжийн зардлын асуудлаас болж хойшлогдон “Чадварлаг багш” арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэхээр ажиллаж байна.	70%	70%	

	40		8.3.. Багш мэргэжлээр дээд боловсрол олгох их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт 6 сарын хугацаатай дадлагажигч багшаар ажиллах агуулгыг багтаана. Дадлагажигч хөдөө орон нутагт ажиллавал тэтгэлэг олгож болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.	Багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд амжилттай суралцаж байгаа хөдөө, орон нутагт багшлах дадлага гүйцэтгэх суралцагчид тухайн сургуулийн нэг жилийн сургалтын төлбөрийн 30%-тай тэнцэх хэмжээний амьжиргааны зардлыг олгох болсон. 2020 онд Ховд их сургууль, Ховд их сургуулийн Баян-Өлгийн салбар сургууль, Дорнод их сургууль, Монгол Улсын Боловсролын их сургуулийн 650 оюутанд 408,5 сая төгрөгийн буцалтгүй тусламж олгосон. /2021 оны төсөвт мөнгө тусгагдаагүй тул хасуулах/	100%	100%	
	41		9.2.. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, мэргэжлийн сургалт, боловсролын сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн зэргийг суралцагчдын сурлагын амжилт, чанар, суралцагч, эсхүл түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн сэтгэл ханамж, заах аргын чадвар, өөрийгөө хөгжүүлсэн байдлыг харгалзан хугацаанаас өмнө нэмэгдүүлж болох бөгөөд холбогдох журмыг боловсролын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран	Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/803 дугаар тушаалаар баталсан. Энэхүү журмын үзэл баримтлал нь байгууллагын тасралтгүй хөгжлийг хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнгээ байгууллага нотолгоонд суурилан багш, ажилтан, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой өөрөө үнэлж, бодит байдлаа мэдэх, хариу арга хэмжээ авах, өөрийн үнэлгээний дүн, дүгнэлт бодитой эсэхийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулж, цаашид сурах, сургах үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох, үнэлгээний үр дүнг бусадтай харьцуулах, эрэмбэлэн жагсаах шинж агуулахгүй, үнэлгээ нь тухайн байгууллагын үйл ажиллагааны ахиц, дэвшлийг үнэлэхэд чиглэгдэв. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/812 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан	70%	70%	

		батална.	“МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, ХАСАХ ЖУРАМ” хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.			
	42	11.3.. Багшид ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллыг олгох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.	БСШУС-ын сайдын А/425 дугаар тушаалд заасны дагуу бага, дунд боловсролын чанарыг улсын хэмжээнд үнэлэх судалгааг 2019 оны 3 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулсан. Энэхүү судалгаа нь бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарыг оновчтой боловсруулсан даалгавраар үнэлэх, боловсролын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж, тэдгээрийн хоорондын хамаарлыг тогтооход чиглэсэн. Энэ удаагийн үнэлгээнд III, X ангийн сурагчдын 12 хувь, IX ангийн сурагчдыг 100 хувийг хамруулж, шалгуулагчид 4 хичээлийн агуулгаар даалгавар гүйцэтгэн үр дүнг гаргалаа. Судалгааны үр дүнгээр IX ангийн сурагчдын шалгалтын дундаж гүйцэтгэл 37.1 хувь (математик 34.8%, монгол хэл 50.5%, физик 26.1%, англи хэл 26.3%)-тай дүгнэгдсэн бол III анги 49.9%, X анги 31.9%-тай гарсан байна. Суурь боловсролын чанарын үнэлгээний судалгааны үр дүнгээр тэргүүлэх амжилт үзүүлсэн ерөнхий боловсролын 40 сургуулийг тодруулж батламж олгов. Мөн боловсролын үйлчилгээний нийтлэг, тогтвортой механизм бүрдүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/803 дугаар тушаалаар батлав. Сургуулийн үйл ажиллагааг 5 чиглэлийн 12 үзүүлэлтэд хамаарах 72 шалгуураар үнэлэхээр боллоо. Дэлхий нийтийг хамарсан цар тахал (COVID-19)-ын халдварын дэгдэлт ихэссэнтэй	70%	70%	

				холбогдуулан улс орнуудад танхимын сургалтыг зогсоож, хөл хорио, хөдөлгөөний хязгаарлалт тогтоосон шалтгааны улмаас багш нарын нээлттэй хэлэлцүүлгийг нэгдсэн байдлаар зохион байгуулах боломжгүй хязгаарлагдмал нөхцөлд хэлэлцүүлгийг Боловсролын үнэлгээний төвөөс удирдан хийлээ. АХБ-ны төслийн хүрээнд багшийн ажлыг үнэлэх үнэлгээний шалгуур боловсруулах ажлын хэсэг байгуулан ажилласан. Чадварлаг багш арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан 2 удаа хэлэлцүүлсний эцэст Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авахаар хүргүүлж, саналыг нэгтгэн Засгийн газрын тогтоол батлуулахаар ажиллаж байна.			
16	43	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай 2019-05-30 Дугаар 2019.05.30	10.1.1. Сургуулийн нэг хүүхдэд ногдох хоолны зардлын нормативыг инфляцийн түвшин болон суралцагчийн шим тэжээлийн хэрэгцээг харгалзан жил тутам шинэчлэн батлах;(10.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	Засгийн газрын 2019 оны "Норматив батлах тухай" 450 дугаар тогтоолоор цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны зардлын норматив хэмжээг шинэчлэн баталсан. 2021 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчид үдийн цайны үйлчилгээнээс үдийн хоолны үйлчилгээнд шилжихтэй холбоотой 2021 онд хоолны зардлын нормативыг шинэчлэн тогтооно.	70%	0%	
	44		10.1.2.. Энэ хуулийн 10.1.1-д заасан зардал болон тухайн жилд сургуулийн	Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цайны үйлчилгээний зардалд 54.2 тэрбум төгрөгийг 2020 оны улсын төсөвт тусган	100%	100%	

		хоол үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахад шаардагдах зардлыг төсвийн төсөлд тусгаж, хэрэгжүүлэх; (10.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	зарцуулж байна. 2021 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөрийг үдийн хоол болгохтой хологдуулан 2021 оны төсвийн төсөлд зардлыг 71 тэрбумаар төлөвлөн төсвийн төслийг хүргүүлсэн бөгөөд 40 тэрбум төгрөг батлагдсан.			
	45	10.1.3.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжсэн үндэсний хөтөлбөр батлах. (10.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар Монгол Улсын Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл үйлчилгээг дэмжсэн үндэсний хөтөлбөрийн 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн Засгийн газрын 207 дугаар тогтоолоор баталсан.	100%	100%	
	46	10.2.1.. Эрүүл мэндийн боловсролын сургалтын хөтөлбөрт зохистой хооллох шим тэжээлийн мэдлэг олгох агуулгыг тусган боловсруулж, хэрэгжүүлэх; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн “Сургалтын хөтөлбөр батлах тухай” А/467 дугаар тушаалаар эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг баталж 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын сургуулийн 4-12 дугаар ангийн сурагчдад 6 чиглэлийн агуулгаар 7 хоногт 1 цагаар эрүүл мэндийн хичээл орж байна. 1. Хувийн эрүүл ахуй ба орчны эрүүл мэнд 2. Хооллолт ба хөдөлгөөн 3. Сэтгэцийн эрүүл мэнд 4. Хорт зуршил 5. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд 6. Аюулгүй байдал, анхны тусламж гэсэн агуулгын хүрээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулийн багш, судлаач, иргэний	100%	100%	

		дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан ажлын хэсэг байгуулан НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр эрүүл мэндийн хичээлийг зааж буй багшид шаардлагатай нэмэлт мэдээлэл, аль болох шинэлэг мэдээ мэдээлэл, аргазүй шаардах сэдвүүдийг сонгож аргачилсан зөвлөмжийн төслийг боловсруулаад байна. Энэхүү зөвлөмж нь багшид хичээлээ үр дүнтэй заахад тулгуур болох бөгөөд хооллолт ба хөдөлгөөний агуулгыг 100 хувь, бусад 5 агуулгыг 60-80 хувийг зөвлөмж болгон бэлтгээд байна.			
	47	10.2.2.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу боловсруулж, батлуулах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай” 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн А/190 дүгээр тушаалаар хүний нөөц бэлтгэх, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний стандарт, хоол, шим тэжээлийн боловсрол олгох ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Дэд ажлын хэсгээс “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний стандартын анхны төслийг боловсруулан, хоол үйлдвэрлэлийн чиглэлийн мэргэшсэн багш, судлаачдаас санал авахаар хүргүүлээд байна. Энэхүү стандартаар боловсролын сургалтын байгууллагын хоол үйлдвэрлэлийн байр, барилга байгууламж, хүний нөөц, тоног төхөөрөмжийн норматив хэмжээ, хоол үйлдвэрлэлийн зохион байгуулалтын үйл ажиллагаа, хоол хүнснээс шалтгаалах хордлогоос урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлын шаардлагыг тогтоож өгөх болно. Хамрах хүрээнд цэцэрлэг, ерөнхий	70%	70%	

				боловсролын сургууль, дотуур байрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын үйл ажиллагааг зохион байгуулах, хоол үйлдвэрлэлийн технологи ажиллагаа болон тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд үнэлгээ хийх, барилга байгууламжид засвар үйлчилгээ хийх, өргөтгөх , зориулалтыг өөрчлөхөд хяналт тавихад мөрдөхөөр тусгасан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/65 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-нд дээрх стандартыг 2021 онд батлуулахаар тусгасан.			
	48		10.2.3.. Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан орон тооны бус Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих орон тооны бус “Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын төслийг боловсруулан 2020 оны 8 дугаар сарын 14-ний өдөр яамны веб сайтад /www.meds.gov.mn/ байршуулсан ба 1000 орчим хүн уншиж танилцсан. Журмын төсөлд санал авахаар 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр аймаг, нийслэлийн боловсролын газарт дотоод сүлжээгээр хүргүүлсэн. Төсөлд Увс аймаг санал ирүүлж, бусад нь дэмжсэн цахим шуудан ирүүлсэн. Увс аймгийн саналыг журмын төслийн 2.5-д тусгасан. Журмын төслийг хуулийн хэлтсээр хянуулан, газар, хэлтсийн хурлаар хэлэлцүүлэн саналыг тусган сайжруулаад байна. Энэхүү журмыг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулна.	70%	70%	
	49		10.2.5.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд	Хяналт тавих журмын төслийг боловсруулсан бөгөөд ЭМЯ, МХЕГ-аас санал авахаар	70%	30%	

		тавих хяналтын журмыг мэргэжлийн хяналтын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батлах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	ажиллаж байна.			
	50	10.2.6.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журмыг батлах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журмын төслийг боловсруулж, 2020 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр яамны веб сайтад /www.meds.gov.mn/ байршуулсан, 778 хүн уншиж танилцсан байна. Төсөлд аймаг, нийслэлийн Боловсролын газруудаас санал авч байна.	70%	70%	
	51	10.2.9.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ	2020-2021 оны хичээлийн жилд нийт сургуулийн 59 хувь нь 5 өдрийн турш халуун	100%	100%	

			явуулахад шаардлагатай хүний нөөц, тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, холбогдон гарах зардлыг төсвийн төсөлд тусгаж, хэрэгжүүлэх; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	хоол өгч байгаа бол 20 хувь нь 5 өдөр бэлэн бүтээгдэхүүнээр, үлдсэн сургууль нь халуун хоол болон бэлэн бүтээгдэхүүн гэсэн холимог байдлаар үйлчилж байна. нийт сургуулийн 62 хувь нь ус цэвэршүүлэгчийг давхар бүрд байршуулан сурагчдыг сургууль дээр ус уух боломжийг бүрдүүлсэн байна •Хоол үйлдвэрлэлийн барилга байгууламж, байрын бэлтгэл ажлыг хангах хүрээнд хоолны газаргүй болон стандартын шаардлагад нийцэхгүй, зориулалтын бус хоолны газартай 206 сургууль байна. Үүний засвар үйлчилгээ хийх шаардлагатай, зардалд нь 35 орчим тэрбум төгрөг шаардагдах төлөвтэй байна. •Төрийн өмчийн сургуулиудаас хоолны газраа өөрсдөө ажиллуулдаг 516 сургууль байгаа бөгөөд дээрх сургуулиудын хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж үзэхэд нийт 372 сургуульд хоол үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмж шаардлагатай зардалд нь 9.6 орчим тэрбум төгрөг шаардагдах төлөвтэй байна. •Энэ хичээлийн жилд 5 аймгийн нийт 36 сургууль хоолны газраа түрээсийн гэрээгээр ажиллуулж байгаагаас зориулалтын бус хоолны газартай 12 сургууль, хоол үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмж шаардлагатай 30 сургууль байна. Нийслэлийн хувьд 9 дүүргийн 107 сургуулийн нийт 118 хоолны газрыг аж ахуйн нэгж, байгууллагатай түрээсийн гэрээ байгуулан ажиллуулж байна. Зориулалтын бус хоолны газартай 58 сургууль, хоол үйлдвэрлэлийн үндсэн тоног төхөөрөмж шаардлагатай 89 сургууль байна. •Сургуульд 455 эмч үдийн цай, дотуур байрын хүүхдийн хоол			
--	--	--	---	--	--	--	--

			үйлдвэрлэлд 1237 тогооч, 442 туслах тогооч ажиллаж байна.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6.5-д заасан ёсоор сургууль бүрд хоол зүйч ажиллах тохиолдолд 672 хоол зүйчийн орон тоо үүсэх шаардлагатай, цалингийн /ТҮЭМ-4-3/ зардалд 8.0 орчим тэрбум төгрөг шаардагдах тооцоотой байна. Сургуульд ажиллаж буй 455 эмчийг хоол зүйчээр хөрвүүлсэн тохиолдолд нийт сургуулийн 67 хувь нь хоол зүйчээр хангагдаж, нэмэлт орон тоо, цалин хөлсний зардал үүсэхгүй байх боломжтой			
	52	10.2.10.. Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах; (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	Сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээнд хяналт тавих журмын төслийг боловсруулж холбогдох газруудаас санал авахаар хүргүүлээд байна. 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс уг журам хэрэгжих эхлэх бөгөөд хяналт шалгалтыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран хийхээр төлөвлөж байна.	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	
	53	10.2.12.. Энэ хуулийн 10.2.11-д заасан хандив, тусламжийг хүлээн авах	Журмын төсөл боловсруулах ажлын хүрээнд аймаг, нийслэлийн сургуулиудын хоолны газар, тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй	Хугацаа болоогүй / үнэлэх	Хугацаа болоогүй / үнэлэх	

			ажлыг зохион байгуулах журмыг батлах. (10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах нэгжтэй байх бөгөөд сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:)	судалгаа болон нийлүүлэлтийн талаарх судалгааг хийсэн. Журмын төслийг боловсруулсан. Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл урлагийн газар, ерөнхий боловсролын сургуулиудын захирлуудыг оролцуулан цахим хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.	боломжгүй	боломжгүй	
17	54	Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай 2020-04-29 Дугаар 2020.04.29	7.1.8.. Өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны хичээл, сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулах, сургалтын төлбөрийг хөнгөлөх, дараагийн төлбөрт шилжүүлэх; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны “Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” А/43 дугаар тушаалыг гаргуулж, их, дээд сургууль, коллежийн хичээл, сургалт, дадлагын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох арга хэмжээ авсан. • Засгийн газрын 139, 168 дугаар тогтоолууд болон Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020-04-03-ны өдрийн “Бүрэлдэхүүн, удирдамж батлах тухай” А/102 дугаар тушаалыг хэрэгжүүлэх хүрээнд Их, дээд сургууль, коллежид сургалтын үйл ажиллагааг 2020-09-01 хүртэл түр зогсоох, цахим хичээлийг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэх, шинэ коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар чиглэл өгч ажилласан. • Монгол Улсын Шадар сайд, Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол,	100%	100%	

			шинжлэх ухааны сайд, Эрүүл, мэндийн сайдын 2020 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн “Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай” 78,А/149,А/164,А/14, А/391 дугаар хамтарсан тушаалыг батлуулсан. Тус хамтарсан тушаалын 5 дугаар заалтаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, политехник коллеж, их, дээд сургууль, коллежийн сургалтын төлбөр, хураамжийг эцэг ,эх, асран хамгаалагчид санхүүгийн дарамт үүсгэхгүйгээр сар, улирлаар төлөх уян хатан зохицуулалт хийх арга хэмжээ авахыг өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллагын удирдах ажилтан нарт үүрэг болгон, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.			
	55	7.1.9.. Бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулсан, хязгаарласан тохиолдолд цахим, эсхүл бусад хэлбэрээр зайн сургалтыг чанартай, хүртээмжтэй хүргэх, багш болон суралцагчийн оролцоо, түүнд тавих хяналтыг сайжруулах; (7.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар Засгийн газар энэ хуулийн 11.1-д заасан	2020-2021 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор танхимын болон танхимын бус /цахим сургалт/ хэлбэрээр зохион байгуулах тухай Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн "Түр журам батлах тухай" А/21 дүгээр тушаалаар "Их, дээд сургууль, коллежийн хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам"-ыг баталсан. • Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн “Их, дээд сургууль, коллежийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зарим зохицуулалт хийх тухай” А/195 дугаар тушаалыг батлуулсан. Тус тушаалаар 2020-	100%	100%	

			шаардлагад нийцүүлэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:)	2021 оны хичээлийн жилд их, дээд сургууль, коллежид оюутан элсүүлэх үндэсний босго оноог тогтоосон. Мөн оны эхний хагаст төлөвлөсөн нэг удаагийн шинжтэй арга хэмжээ, бүх төрлийн уралдаан, тэмцээн, сургалт-семинар, гадаад, дотоод томилолт, тогтмол зардал /ус, цахилгаан, халаалт/, урсгал болон их засвар, тавилга, тоног төхөөрөмж худалдан авах гэт мэт тэвчиж болох зардлыг хэмнэж, сургуулийн төсөвтөө тодотгол хийх асуудлыг Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх чиглэлийг өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.			
18	56	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01	13.3.. Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, батлан хэрэгжүүлнэ.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын хүрээнд хэрэгжүүлэх Хөгжлийн зорилтот хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулахаар 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан.	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	
	57		21.5.. Салбарын хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын хэмжээнд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зорилтын биелэлтийг жил бүр тогтоосон хугацаанд Засгийн газарт ирүүлнэ.	Салбарын хэмжээнд хэрэгжиж буй Хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхээр Бодлого төлөвлөлтийн газрын 2021 оны төлөвлөгөөнд тусгасан.	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	
УИХ-ын тогтоол							
19	58	Хөгжлийн бэрхшээлтэй	1.2.. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Тушаалын хавсралтад	100%	100%	

		иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2013-02-08 Дугаар 2013.02.08 №19	боловсролын үйлчилгээг тусгай сургууль болон сэргээн засалтын бусад төрөлжсөн байгууллага эзэмшүүлэх ажлыг шинэчлэн зохион байгуулах;	нэмэлт оруулах тухай” А/625 дугаар тушаалаар Боловсролын хүрээлэнд шинээр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил, боловсрол, арга зүйн сектор”-ийг байгуулсан. Тус сектор нь эрдэм шинжилгээ, судалгаа хийх, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх арга зүй боловсруулах чиг үүрэгтэй ажиллаж байна. Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг болон Өвөрхангай, Ховд аймгийн 8 сургууль, 8 насан туршийн боловсролын төвд болон НҮБ-ын хүүхдийн сангийн “Тэгш хамруулан сургах” төслийн хүрээнд Баянхонгор, Говь-Алтай, Завхан аймгийн 9 сургууль, Улаанбаатар хотын 12 сургуульд хүүхэд хөгжлийн танхим байгуулагдан ажиллаж байна. Мөн 2020 онд Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлээр Боловсрол, шинжлэх ухааны яамнаас хэрэгжүүлж буй “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах зорилгоор Архангай, Булган, Дорноговь, Өмнөговь, Сүхбаатар, Завхан, Төв, Хэнтий аймгуудын төвийн сургуульд "Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим" байгуулан нийт 265,2 сая төгрөгийн өртөг бүхий ном, тавилга, тоног төхөөрөмж, тоглоом, туслах хэрэгсэл нийлүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.9.3-т "тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх" арга хэмжээ тусгагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны ээлжит хуралдаанаар батлагдсан "Тэгш хамран сургах боловсролын талаар авах			
--	--	---	--	--	--	--	--

				зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолд "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулж буй тусгай цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчин нөхцөлийг сайжруулан хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх, тэдэнд мэргэжлийн чиг баримжаа олгох, багш, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийг зөвлөгөө, мэдээлэл, арга зүйгээр хангах ажлыг зохион байгуулах мэргэжил, арга зүйн төв болгон хөгжүүлэх, багш, мэргэжилтнийг чадавхжуулах ажил хийгдсэн			
	59		1.3.. Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах чиглэлээр мэргэших дохионы хэлний багш, арга зүйч, эмч, согог зүйч зэргийг бэлтгэх зорилгоор нийт 20-оос доошгүй хүнийг жил бүр гэрээгээр, сургалтын төрийн сангийн зардлаар гадаадад сургах арга хэмжээ авах.	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй ажиллах чиглэлээр мэргэших дохионы хэлний багш, арга зүйч, эмч, согог зүйч зэргийг бэлтгэх зорилгоор 2018 оны 11 сараас ОХУ-ын Эрхүү хотын Багшийн сургуультай хамтын гэрээ байгуулж 10 хүнийг, Польш болон Унгарт 10 гаруй багш нарыг боловсролын зээлийн сангийн зардлаар сургаж гадаадад 20 гаруй хүнийг сургасан байна. 2020/2021 оны хичээлийн жилд Оросын Засгийн газрын квотод тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр 33 квот оруулсан. Мөн Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зохион байгуулах "Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн боловсролд тулгамдаж буй асуудал, цаашдын шийдэл хэлэлцүүлэг"-т ОХУ, Японы мэргэжилтэн-эксперт (Москвагийн Багшийн их сургуулийн Согог зүйн факультетын декан Е.В.Кулакова, ...) -г оролцуулсан. Түүнчлэн Засгийн газрын 2020 оны 70 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад заасан Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх	100%	100%	

				чиглэл дотор тусгай хэрэгцээт боловсролын багш мэргэжлийг тусгасан болно. 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар батлагдсан "Тэгш хамран сургах боловсролын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын 1.4-т "тэгш хамран сургалтын чиглэлээр мэргэшсэн багшийг бэлтгэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чиглэлээр багш, албан хаагчдыг давтан бэлтгэх ажлыг бодлогоор дэмжиж, Засгийн газар хоорондын гэрээгээр болон гадаад улс орны Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах хяналтын тоог жил бүр тогтоон мөрдөх;" гэж тусган хэрэгжүүлэхээр ажиллаж байна.			
20	60	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2015-12-03 Дугаар 108-2015-12-30	1.1. 1/Улсын төсвийн хөрөнгөөр 2016 онд санхүүжүүлж хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтаас хасагдсан, хавсралтад заасан төсөл, арга хэмжээнээс нэг маягийн зураг төслөөр барьж болох, 320 хүртэлх суудалтай сургууль, цэцэрлэг, дотуур байрын барилгыг 2016 оны 1 дүгээр улиралд багтаан концессоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, улсын төсвөөс санхүүжүүлэхээр төсөвт тусган ажиллах;	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан 2016 онд хэрэгжүүлэх ажлыг даалгасан тогтоол байсан. Улсын Их Хурлаар Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2016 оны 09 дүгээр сарын 09 -ны өдөр баталсан. 2016 онд шинээр батлагдсан 5 төсөл, арга хэмжээнүүд нь тухайлсан зурагтай байсан бөгөөд бүгд хэрэгжиж дууссан.	100%	100%	

21	61	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2016-09-09 Дугаар 2016 №47	1.в/. Уул уурхайгаас бусад салбарыг хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн боловсруулах, дэд бүтэц, мал аж ахуй, аялал жуулчлал, шинжлэх ухаан болон био технологийн салбаруудад хөрөнгө оруулалтыг татах; (1/Төсвийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр:)	ШУ-ны Паркийн захиргаа байгуулсан зорилгод инновацийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх дэд бүтэц, орчныг бүрдүүлэх, импортыг орлох, экспортод чиглэсэн өндөр технологи, инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шаардагдах санхүүгийн олон талт эх үүсвэрээр хангах орно. Гарааны компанийн зорилго Инновацийн тэргүүлэх чиглэл батлуулсан зорилгод эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, өндөр технологийн болон өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх, экспортлох, өндөр үр ашигтай үйлчилгээний төрөл, хэлбэрийг бий болгох, үндэсний инновацийн чадавх, нөөцийг оновчтой ашиглах, инновацийн талаарх төрийн дэмжлэгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ. Хэрэгжүүлэх арга хэмжээнд Тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга хамтран хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.	70%	70%	
22	62	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2016-11-03 Дугаар 2016 №51	2.. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар	БСШУС-ын сайдын 2019 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн “Хөтөлбөр, төлөвлөгөө, зөвлөмжийг хэрэгжүүлэх зарим арга, хэмжээний тухай” А/373 дугаар тушаал, Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын газрын дарга нарт тус тус 2019 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 1а/5297, 1а/5298, 1а/5299 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг хүргүүлэн ажиллаж байгаа болно. БСШУС-ын сайд Ё.Баатарбилэг,	100%	100%	

			/Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай.	Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар 3.Дашдаваа нар хамтран ажиллах тухай “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-г /хугацаатай 21 хэрэгжүүлэх ажил бүхий/ хамтран батлан, хэрэгжүүлж байна. Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх , соён гэгээрүүлэх хэлтсээс ирүүлсэн албан бичиг болон холбогдох ажилтны зааврын дагуу дараах баримтуудыг гаргаж хүргүүлэв. Үүнд: 1. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах албанаас ирүүлсэн Мөрдөн байцаагчийн 2020 оны 29, 46 дугаар мэдэгдлийн хариу, 2. Боловсрол, шинжлэх ухааны яам болон салбарын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны тайлан, 3. Боловсрол, шинжлэх ухааны яаманд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн мэдээлэл, үйл ажиллагааны тайлан, 4. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас олгож буй тусгай зөвшөөрөл түүний мэдээлэл, 5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын хийсэн 2020 оны тайлан, зөрчлийн биелэлт, 6. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг төлөвлөгөөний биелэлт, 7. Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын “Тушаал хүчингүй болгох тухай” А/33 тушаалаар Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, тариф батлах тухай” А/528 дугаар тушаалыг хүчингүй болгосон тушаалын хуулбарыг тус тус хүргүүлсэн.			
--	--	--	---	---	--	--	--

				Боловсрол, шинжлэх ухааны яамны Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж бэлэн болгосон.			
23	63	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017-06-09 Дугаар 2017 №46	1.4.. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвөөр дамжуулан хэвтрийн, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд бичиг үсгийн болон бага, суурь боловсрол эзэмшүүлэх ажлыг 2017-2018 оны хичээлийн жилээс эхлүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, тохирох хэрэглэгдэхүүнийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн байгаа орчинд суурилуулах, зайн сургалтын тоног төхөөрөмж худалдан авах зардал, багшийн цалинг тооцож улсын төсөвт тусгах;	БСШУС-ын сайдын 2018 А/155 дугаар “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, боловсруулах аргачлал батлах тухай” тушаал гарсан. 2019-2020 оны хичээлийн жилд Хөгжлийн бэрхшээлтэй нийт суралцагчийн тоо 896, үүнээс эмэгтэй 345, эрэгтэй 551 байна. Нийт суралцагчдын 29 нь хэвтрийн, 80 нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй байна. Хүүхдийг Ивээх Сангийн “Монгол улсын хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн хүрээнд насан туршийн боловсролын төвүүдийн гэр сургалтад хамрагдаж буй хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг 2020 оны 5 дугаар сард төсөл хэрэгжиж буй Ховд, Өвөрхангай аймаг, Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн Насан туршийн боловсролын төвүүдээс авсан. Судалгааны дүнгээс үзэхэд төсөл хэрэгжиж буй орон нутгийн насан туршийн боловсролын төвүүдэд явуулын багшаар дамжуулан гэрээр сургалтад хамрагдаж байгаа 6-17 насны хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй нийт 35 хүүхэд байна. Судалгаанд хамрагдагсдын 65.7 хувь буюу 23 нь эрэгтэй, 34.3 хувь буюу 12 нь эмэгтэй байна. Дэлхий нийтээр үүсээд буй цар тахлын нөхцөл байдлын улмаас уг сургалтыг одоогийн	100%	100%	

				байдлаар түр зогсоогоод байна.			
	64		1.6.. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг эрт илрүүлэн оношлоход шаардагдах оношилгооны иж бүрэн тоног төхөөрөмж, тусгай хэрэгцээт сургуулийн зориулалтын тохирох хэрэглэгдэхүүн, сургалтын хүртээмжтэй материал, хэрэгсэл, сурагчдыг тээвэрлэх автобусаар хангах;	2020-2021 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа харааны бэрхшээлтэй болон сонсголын бэрхшээлтэй хүүхдийн суралцах орчин, нөхцөлийг дэмжин сайжруулах талаар авах арга хэмжээний төсөл боловсруулж, хэрэгжүүлэн ажиллалаа. Энэхүү арга хэмжээний хүрээнд 70 сая төгрөгийн зардлаар 4-12 дугаар ангийн 27 нэрийн сурах бичгийг брайлаар хэвлэн, 6-12 дугаар ангийн 18 нэрийн сурах бичгийг цахим /DAISY/ хэлбэрт хөрвүүллээ. -Мөн 40 сая төгрөгийн зардлаар сонсголын бэрхшээлтэй хүүхдийн болон харааны бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг шийдвэрлэн 29-р сургуульд 25ш зурагт, 116-р сургуульд 2ш компьютерын монгол цахим брайл гар, 2ш монгол брайлийг дэмждэг Даксберри программыг тус тус хүлээлгэн өглөө. -Япон Улсын Жайка ОУБ-н санхүүжилтээр ерөнхий боловсролын 116 дугаар сургуулийн багш, сурагчдыг 60 нэр төрлийн сурах бичгийг сонсдог хэлбэрээр суулгасан, 160ш цахим ном уншигч DAISY-E-PUB төхөөрөмжөөр бүрэн хангасан. -2020 онд нийт 25 сая төгрөгийн санхүүжилтээр 29-р сургуульд 25ш зурагт, 116-р сургуульд 2ш компьютерын монгол цахим брайл гар, 2ш монгол брайлийг дэмждэг Даксберри программ, 60 нэр төрлийн ном, сурах бичгийг сонсдог хэлбэрээр суулгасан 174ш цахим ном уншигч DAISY-E-PUB төхөөрөмжийг тус тус хүлээлгэн өгч, сонсголын бэрхшээлтэй хүүхдүүд үгийн баялгийг нэмэгдүүлэх, хэл	100%	100%	

			яриаг хөгжүүлэх, сургалт зохион байгуулахад нэн шаардлагатай хэрэглэгдэхүүн болох телевизээр хангагдаж, харааны бэрхшээлтэй сурагчид брайл болон сонсдог /DAISY-E-PUB/ хэлбэрийн сурах бичиг, /DAISY-E-PUB/ ном уншигч төхөөрөмжөөр хангагдлаа2020 онд ЕБС-ын 40 барилга, цэцэрлэгийн 54 барилга ашиглалтад оруулж, шилжих зориулалтын 130 барилгад нийт 268.5 тэрбум төгрөг зарцуулж байна. Шинээр ашиглалтад орж буй барилгууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан орц, гарц, налуу шат хийгдсэн байна.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх олон улсын стандартад нийцсэн орчин нөхцөлтэй ясли, цэцэрлэгийн цогцолбор ашиглалтад орсон.			
	65	1.8.. Тусгай хэрэгцээт боловсролын байгууллагын багшлах боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тэгш хамруулан сургах хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад даалгах;	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад эхний болон тав, арав дахь жилдээ ажиллаж буй багш, ажилтанд зориулсан үндсэн сургалтад нийт 1,316 багш, арга зүйч, эрхлэгч хамрагдсан бөгөөд сургалтын хөтөлбөрт “Хэлний бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх, оролцоо, хөгжлийг дэмжих” арга зүй сэдвийг сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжилтийг ханган ажилласан байна. 17 аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар БМДИ, Сургуулийн өмнөх боловсролын сургууль зэрэг 8 байгууллагатай хамтран "Хөгжлийн бэрхшээлийн тухай ойлголт /нийгмийн загвар/", "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга барил", "Хөгжлийн бэрхшээлтэй байж болзошгүй, хөгжлийн бэрхшээлтэй	100%	100%	

				хүүхдийг гэр бүлд нь хөгжлийг дэмжих Портеж хөгжлийн зориулалт, ажиллах арга зүй" сэдвээр 1,584 багш, туслах багш, эцэг эхэд зориулсан сургалтыг зохион байгуулсан. Мэргэжил дээшлүүлэх танхимын сургалтаар 10 дахь жилдээ ажиллаж буй нийт 14 мэргэжлийн 1200, 5 дахь жилдээ ажиллаж буй 13 мэргэжлийн 722, эхний жилдээ ажиллаж буй 13 мэргэжлийн 1360, нийт 3291 багш ажилтнуудад тэгш хамруулан сургах боловсролын агуулга сэдвээр 112 цагийн хичээл бэлтгэн зааж, мэдлэг ойлголт, арга зүйн хөгжлийг дэмжлээ. БМДИ-ийн 2020-2021 оны хичээлийн жилийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад тусгай хэрэгцээт боловсролын чиглэлээр 26 багш хамрагдан онлайнаар суралцаж байна. Мөн 2020 оны 20 дугаар сард МУБИС-ийн тусгай хэрэгцээт боловсролын тэнхимийг 17 төгсөгч "Тусгай хэрэгцээт боловсролын багш" мэргэжлээр төгсөж ажлын байраар хангагдсан байна.			
24	66	Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-05 Дугаар 2018 №02	1.3/. Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах зорилгоор нийслэлээс орон нутаг руу ажиллаж амьдрах иргэдийн санал санаачилгыг дэмжих бодлого боловсруулан хэрэгжүүлэх, аян өрнүүлэх, дагуул хотуудыг бий болгож шинжлэх ухаан, технологи, инноваци, аялал жуулчлал, аж үйлдвэр, худалдааны чиглэлээр төрөлжүүлэн хөгжүүлэх, төрийн зарим	Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх талаар УИХ-ын тогтоол, Засгийн газраас гарсан тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор БСШУС- ын сайдын 2019 оны А/73 тоот тушаалаар ажлын хэсэг байгуулагдан шинэчилсэн судалгаа хийж, орон нутагт их сургуулиудын хотхоныг төлөвлөсөн байдал, ажлын явцын талаар Засгийн газарт хүргүүлэх санал боловсруулан танилцуулга бэлтгэн хүргүүлсэн. Улаанбаатарын дагуул хотуудад ХААИС болон ШУТИС-ийн салбар сургуулийг байрлуулан хотхоноор хөгжүүлэх төсөл боловсруулсан.	100%	100%	

			байгууллага болон төрийн өмчит их, дээд сургуулийг хотоос гаргах, тэдгээрийг холбосон хурдны зам, метро байгуулах урьдчилсан тооцоо судалгаа хийж, нийслэл хотын зарим чиг үүргийг аймгийн зэрэглэлтэй болон дагуул хот руу шилжүүлэх зэрэг асуудлыг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан судалж, холбогдох шийдвэрийг гаргах;				
	67		1.7/. Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах, урьдчилан сэргийлэх хүрээнд улсын хэмжээнд сургуулийн өмнөх, ерөнхий болон мэргэжлийн боловсрол, дээд сургуулийн хичээлийн жил эхлэх, дуусах болон улирлын амралтын хуваарийг өөрчлөх асуудлыг судалж, 2018 онд багтаан шийдвэрлэж, хэрэгжүүлэх.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/747 дугаар тушаалаар хичээлийн жилийн бүтцийг өөрчилж улирлын амралтын хугацааг 12-1 дүгээр сард болгож өөрчилсөн болно.	100%	100%	
25	68	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2019-05-30 Дугаар 2019 №53	1.1/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан хоол зүйчийг боловсролын	Засгийн газрын тогтоолоор батлуулах Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах хүний нөөцийг бэлтгэх үйл	70%	70%	

		асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн бэлтгэх, төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн эмчийг хөрвөх сургалтад хамруулан 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн хүний нөөц бүрэн бэлтгэгдэх хүртэлх хугацаанд сургуулийн хоол зүйчээр ажиллуулах ажлыг зохион байгуулах;	ажиллагааны хүрээнд сургуульд ажиллаж буй эмч болон хоол, хүнсний чиглэлийн мэргэжлийн ажиллагсдыг хоол зүйчээр хөрвүүлэн бэлтгэх арга хэмжээнд 2021 онд нийт сургуулийн 25 хувь буюу 165 сургууль, 2022 онд 30 хувь буюу 149 сургууль, 2023 онд нийт сургуулийн 40 хувь буюу 138 сургууль, 2024 онд үлсэн 200 орчим сургуулийг хоол зүйчээр хангахаар тусгасан. 2020-2021 оны хичээлийн жилд сургуульд ажиллаж буй 455 эмчийг хоол зүйчээр хөрвүүлсэн тохиолдолд нийт сургуулийн 67 хувь нь хоол зүйчээр хангагдах боломжтой юм.			
	69	1.2/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасны дагуу өдрийн хоолны үйлчилгээнд бага ангийн суралцагчдыг 2021-2022 оны, дунд ангийн суралцагчдыг 2022-2023 оны, ахлах ангийн суралцагчдыг 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн хамруулах;	Улсын хэмжээнд 2020-2021 оны хичээлийн жилд нийт ерөнхий боловсролын 840 сургуульд 680 847 хүүхэд суралцаж байгаагаас 1-5 дугаар ангийн 359 904 сурагч “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн байршил, өмчийн хэлбэр, өрхийн орлого, эрүүл мэнд, иргэншлийн ялгаатай байдал зэргээс үл хамааран сургуульд суралцаж буй бага ангийн бүх сурагчид улсын төсвөөс үдийн цайны үйлчилгээг тэгш хүргэж байна. Энэ хичээлийн жилд нийт сургуулийн 59 хувь нь 5 өдрийн турш халуун хоол өгч байгаа бол 20 хувь нь 5 өдөр бэлэн бүтээгдэхүүнээр, үлдсэн сургууль нь халуун хоол болон бэлэн бүтээгдэхүүн гэсэн холимог байдлаар үйлчилж байна. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчид 2021 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс үдийн хоолны	100%	100%	

			үйлчилгээнд шилжинэ.			
70		1.3/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5-д заасан ажилтны цалингийн зардлыг 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн улсын төсвөөс санхүүжүүлэх;	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд ажиллах хүний нөөцийг бэлтгэх арга хэмжээний хүрээнд цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох үйл ажиллагаанд улсын төсвөөс санхүүжилт шаардах бөгөөд 2021 онд бодлогын баримт бичгийг боловсруулахаар төлөвлөсөн. 2022 оноос аймаг, нийслэлийн Боловсролын газарт нэг мэргэжилтэнд цэцэрлэг, сургууль, дотуур байрын хоол хүнсний асуудлыг хариуцан ажиллуулахаар төлөвлөсөн бөгөөд шинээр орон тоо үүсгэсэн тохиолдолд цалингийн зардалд 700 орчим сая төгрөг шаардагдана. Төлөвлөгөөнд тусгагдсанаар 2023 оноос 97 хоол зүйчийг /5-7 сургуулийн дунд нэг хоол зүйч/ ажиллуулахад цалингийн /ТҮЭМ-4-3/ зардалд 2.3 орчим тэрбум төгрөг шаардагдах тооцоо гарч байна. 2024 онд нийт сургуулийн 50-аас доошгүй хувийг хоол зүйчээр хангахаар төлөвлөсөн нь сургуульд ажиллаж буй эмчийг 2021 оноос хоол зүйчээр хөрвүүлэн бэлтгэснээр хангагдах хувь хэмжээ юм.	100%	100%	
71		1.4/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан байрын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжид шаардагдах зардлыг энэ тогтоолын 8 дахь дэд заалтад заасан	Засгийн газрын тогтоолоор батлуулах Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэх үйл ажиллагааны хүрээнд 3 арга хэмжээ тусгагдсан байна. 1. Ерөнхий боловсролын 206 сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээний газрыг өргөтгөн	100%	100%	

		төлөвлөгөөний дагуу тухайн жилийн төсвийн төсөлд тусган улсын төсвөөс санхүүжүүлэх;	засварлахад нийт 35 орчим тэрбум төгрөг шаардагдах тооцоотой байна. 2021 онд дээрх сургуулийн 25-30 хувь буюу 51-61 сургууль, 2022 онд 30-40 хувь буюу 46-58 сургууль, 2023 онд 45-70 хувь буюу 49-61 сургууль, 2024 онд үлдсэн 45 сургуулийг засвар үйлчилгээнд хамруулахаар төлөвлөсөн. 2021 оны улсын төсөвт 11 сургуулийн засвар үйлчилгээний зардалд 3.0 тэрбум төгрөг тусгагдсан байна. 2. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмж шаардлагатай 372 сургууль, тэдгээрт 9.6 тэрбум төгрөг шаардагдах тооцоотой байна. 2021 онд нийт дээрх сургуулийн 20-25 хувь буюу 74-93 сургууль, 2022 онд 30-40 хувь буюу 89-111 сургууль, 2023 онд 40-55 хувь буюу 83-92 сургууль, 2024 онд үлдсэн 101 сургуульд тоног төхөөрөмж нийлүүлэхээр төлөвлөсөн. 2021 оны улсын төсөвт сургуулийн тоног төхөөрөмжийн зардалд 5.3 тэрбум төгрөг тусгагдсанаас хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмжид тодорхой хувийг нь зарцуулахаар төлөвлөж байна.			
	72	1.5/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасан зардлын нормативыг инфляцийн түвшин болон суралцагчийн шим тэжээлийн хэрэгцээг харгалзан Монгол Улсын Засгийн газраас жил тутам	Сургуулийн үдийн цайны зардлыг Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан бөгөөд бага ангийн сурагчид 2021 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс үдийн хоолны үйлчилгээнд шилжихтэй холбогдуулан 2021 онд Засгийн газраас үдийн хоолны зардлын нормативыг батална.	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	

		шинэчлэн батлах;				
73		1.6/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10.2.12-т заасан хандив, тусламжийг хүлээн авах ажлыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгаар холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;	Журмын төсөл боловсруулах ажлын хүрээнд аймаг, нийслэлийн сургуулиудын хоолны газар, тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй судалгаа болон нийлүүлэлтийн талаарх судалгааг хийсэн. Журмын төслийг боловсруулан Аймаг, нийслэлийн Боловсрол, соёл урлагийн газар, ерөнхий боловсролын сургуулиудын захирлуудыг оролцуулан цахим хурлаар хэлэлцүүлэхээр төлөвлөн 2021 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахаар ажиллаж байна.	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	
74		1.7/. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай байрын түрээсийн гэрээг харилцан тохиролцож дуусгавар болгох ажлыг энэ тогтоолын 8 дахь дэд заалтад заасан төлөвлөгөөний дагуу зохион байгуулах;	Засгийн газрын тогтоолоор батлуулах Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрыг стандартын шаардлагад нийцүүлэх үйл ажиллагааны 3 дугаар арга хэмжээнд түрээсийн гэрээг дуусгавар болох асуудал тусгагдсан байна. 2020-2021 оны хичээлийн жилд орон нутгийн ерөнхий боловсролын 36 сургууль, нийслэлийн ерөнхий боловсролын 107 сургууль цайны газрыг иргэн, аж ахуйн нэгжид түрээслэн бага ангийн сурагчдын үдийн цайны үйлчилгээг үзүүлж байна. Төлөвлөгөөний төсөлд 2021 онд орон нутгийн сургуулийн 80-100 буюу 28-36 сургууль, нийслэлийн сургуулийн 10-20 хувь буюу 10-21 сургуулийг, 2022 онд нийслэлийн сургуулийн 40 хувь буюу 34-38 сургууль, 2023 онд нийслэлийн сургуулиудын 50 хувь буюу 26-29 сургууль, 2024 онд нийслэлийн үлдсэн 28	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	

				сургуулийн түрээсийн гэрээг дуусгавар болгохоор төлөвлөсөн байна.			
	75		1.8/. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөг Монгол Улсын Засгийн газар батлах.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах ажлын төлөвлөгөөний төсөл, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж БШУ-ны Сайдын “Санал авах тухай” 2020.11.11-ны өдрийн 1а/2779 дугаар албан бичгээр 13 яамдаас санал авсан бөгөөд 12 яам дэмжсэн, 3 яам санал ирүүлсэн, Сангийн яам нэмэлт мэдээлэл, тооцоолол ирүүлэхийг хүссэн учир төлөвлөгөөний төсөлд тусгагдсан санхүүжилт шаардагдах 3 арга хэмжээнд нэмэлт тайлбар, тооцооллыг хийж БШУ-ын Сайдын “Хариу хүргүүлэх тухай” 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 1а/3351 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Сангийн яамнаас тайлбар мэдээллийг хүлээн авч, тогтоолын төсөл болон төлөвлөгөөний төсөлд тусгах 4 санал ирүүлснийг тусган сайжруулж, БШУ-ны сайдын 2021 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 1а/40 дүгээр албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлээд байна. Төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх, сурагчдыг үдийн хоолны үйлчилгээнд хамруулахад нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай 2 багц асуудлын хүрээнд 7 арга хэмжээг 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр тусгасан.	70%	70%	
26	76	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын	1.4/б/. эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтны сургалтын	2020 оны эхний хагас жилийн байдлаар мэргэжил дээшлүүлэх үндэсний сургалтыг танхимаар зохион байгуулах сургалт "COVID	100%	100%	

		талаарх 18 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2019-06-06 Дугаар 2019 №62	хөтөлбөрийн багцад хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай сургалтыг оруулж, үе шаттайгаар зохион байгуулах;	19" цар тахалтай холбоотойгоор БСШУС-ын сайдын 04 сарын 17-ны А/194 дугаар тушаалын хүрээнд цахим хэлбэрээр сургалт зохион байгуулагдсан. Нийгмийн ажилтны сургалтыг "Судалгааны арга зүй, МХХТ" агуулгаар зохион байгуулсан. "Тэгш хамран сургах" агуулгыг Мэргэжил дээшлүүлэх үндэсний сургалтад бүх зорилтот бүлгээрээ олгодог. Иймээс "Тэгш хамран сургах" агуулгыг 2 дахь цахим сургалтаараа төлөвлөсөн ба тус агуулгыг 2020 онд эхний ба 5 болон 10 дахь жилдээ ажиллаж буй 105 нийгмийн ажилтан судалсан.			
	77		1.5/б/. хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх зорилгыг бүх шатны боловсролын хичээлийн хөтөлбөрт тусгах;	Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа Боловсролын хүрээлэнгээс 2019 онд бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг сайжруулахдаа “Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх зорилгыг бүх шатны боловсролын хөтөлбөрт тусгах” зорилтыг хэрэгжүүлсэн болно. Үүнд: БСШУС-ын сайдын 2019 оны А/492 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг сайжруулан баталсан. БСШУС-ын сайдын “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2019 оны А/491 дүгээр тушаалаар бага, дунд, ахлах ангийн сурагчид “Иргэний ёс зүйн боловсрол” хичээлийг долоо хоногт тус бүр 2 цагаар судлахаар баталсан. “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийн зорилго нь хүнлэг энэрэнгүй, билиг оюун төгөлдөр, монгол үндэстнийхээ хэл, соёлыг эзэмшсэн, бахархаж хэрэглэдэг, хүндэлж хамгаалдаг, эх орноо эрхэмлэн	100%	100%	

				дээдлэх үүрэг, хариуцлагаа ухамсарласан монгол иргэнийг өсгөх, хүмүүжүүлэх, бэлтгэхэд чиглэж байна			
27	78	Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай 2020-04-09 Дугаар 2020 №21	Дөрөв.4/. дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг нэвтрүүлж төр, хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчийг цахимаар ажиллах нөхцөлийг хангах, боловсролын алсын зайн сургалтын үйлчилгээг үзүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах хяналт бүхий цахим худалдааг дэмжих, импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодод үйлдвэрлэдэг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хангамжийг сайжруулах зэрэг арга хэмжээнд шаардлагатай үнэ, тарифын хөнгөлөлтийг үзүүлэх, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	“Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг онлайн хэлбэрт шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” БСШУС-ын сайдын 2020 оны А/105 дугаар тушаал гарч, тус институтээс танхимд зохион байгуулагдах байсан үндсэн сургалтыг зайн сургалтаар зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Зайн сургалтын эхний шатыг БСШУСЯ-аас тендер зарлаж, Эй Плас интернэйшнл (A Plus international) компани шалгарч, зайн сургалтыг зохион байгуулсан. Зайн сургалтын эхний шатанд 1,5,10 дахь жилдээ ажиллаж буй нийт 5510 багш, удирдах болон бусад ажилтан хамрагдахаас 4787 хүн буюу 87% нь хамрагдсан. “Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/43 дугаар тушаалыг үндэслэн гаргасан “Теле хичээл заах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай” Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын захирлын 2020 оны А/05 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, СӨББ, ЕБС, их дээд сургуулийн багш нар болон Монголын телевизүүдийн холбоотой хамтран Теле хичээлийг 2020 оны 02 дугаар сарын 03-аас зохион байгуулан ажиллаж байна. Монголын телевизүүдийн холбооны нийт 14 телевизийн 170 ажилтан болон СӨБ-ын 20 багш, ЕБС-ийн 314 багш,	100%	100%	

				Тусгай хэрэгцээт боловсролын 28 багш, дохионы хэлний орчуулагч, хэлмэрч 20 багш нийт 710 хүн Теле хичээл бүтээх ажилд оролцож ажилласан байна. байна. Хэдийгээр теле хичээл нь онцгой байдлын нөхцөлд эрсдэлээс сэргийлсэн тохиромжтой арга боловч нөгөө талаас суралцагчдад хүрэх хүртээмж, хичээлийн чанар агуулга, тохиромжтой байдал зэрэг нь бодит байдал дээр хэрхэн хэрэгжсэн талаар олон хүнд эргэлзээ төрүүлж буй. Учир нь зайны сургалт (теле, цахим гэх мэт)-ын үр нөлөө, тохиромжтой байдалтай холбоотой үнэлгээний ажил ховор байдаг. Иймд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан (НҮБХС) болон БШУЯ хамтран “Онцгой байдлын үеийн теле хичээлийн үр дүн, тохиромжтой байдал”-ийг үнэлэх судалгааны ажлыг хийлгэсэн.			
28	79	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай 2020-12-04 Дугаар 2020 №39	1.1/. 1.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай: 1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсвийн орлого нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгө	Боловсрол, шинжлэх ухааны төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын байгууллагуудын санхүүжилтийн сар улирлын хуваарийг улсын төсвийн эх үүсвэр болон Сангийн сайдын өгсөн чиглэлийн хүрээнд нийцүүлэн боловсруулж батлуулсан. Цаашид төсвийн жилийн хугацаанд өр төлбөргүй ажиллах чиглэлийг багцын байгууллагуудад үүрэг болгох, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, цаг тухайд нь шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж ажиллаж байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулах Засгийн газрын зарим чиг үүргийг төлөөлөх хэрэгжүүлэх	100%	100%	

		оруулалтын үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, бүх салбарын төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх;	гэрээнд 2021 оны төсвийн хэрэгжилтийг Төсвийн хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу төсвийн зарчим, сахилга бат, 2021 оны төсвийн онцлогт нийцүүлэн зохион байгуулах зохицуулалтыг оруулж, хэрэгжилтийн удирдлагыг эхлүүлээд байна. Цаашид салбарын төсвийн үр ашгийг дээшлүүлэх зорилгоор төсвийн норм нормативыг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүдийг үе шаттайгаар шинэчлэх ажил хийгдэж байна.			
	80	1.2/. Төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гарган, хэрэгжилтийг хангаж ажиллах;	Үндэсний аудитын газраас ирүүлсэн санхүүгийн аудитын тайланд дүгнэлт хийсний үндсэн дээр дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаа. Үүнд: Харьяа байгууллагын удирдлагад зөрчлийг арилгах, дахин давтан гаргахгүй байх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын төлөвлөгөөг гаргаж ирүүлэхийг албан бичгээр үүрэг болгон ажилласны дүнд 15 байгууллагаас зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын төлөвлөгөөг гаргаж ирүүлснийг нэгтгэн хяналт тавьж ажиллаа. БСШУС-ын сайдын 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 1а/3335 “Үүрэг өгөх тухай”, дэд сайдын 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 1б/26 тоот “Зөвлөмжийн хэрэгжилтийн тухай” албан бичгийг харьяа байгууллагад хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулан ажиллаа. Сөрөг болон хязгаарлалттай санал дүгнэлт авсан байгууллагуудад эрсдэлийн үнэлгээг хийж сүүлийн хагас жилийн төлөвлөгөөнд тусган ажилласан.. Дотоод хяналтын журмыг БСШУС-ын сайдын 2020 оны А/273 тоот тушаалаар батлуулж, харьяа	100%	100%	

			байгууллагуудад хэрэгжилтийг ханган ажиллуулахаар хүргүүлээд байна. 2. Үндэсний аудитын газрын төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг хангаж, хяналтыг сайжруулах, зөвлөмжийн үр нөлөөг дээшлүүлэх ажлын хүрээнд: Үндэсний аудитын газраас 2019 онд хийсэн санхүүгийн хяналт шалгалтаар нийт 80,590.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 108,9 сая төгрөгийн зөрчилд 46 төлбөрийн акт тогтоож, 46,208.6 сая төгрөгийн зөрчилд 87 албан шаардлага, 34,273.0 сая төгрөгийн алдаа зөрчилд 261 зөвлөмж өгсөн. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын актын хэрэгжилтийг мөнгөн дүнгээр авч үзвэл 89.0 сая төгрөгийг төвлөрүүлж 97 хувьтай, албан шаардлагын хэрэгжилт 74 хувь, зөвлөмжийн хэрэгжилт 90,6 хувийн биелэлттэй байна. Актын хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн 23 байгууллага, 50-70 хувь хэрэгжүүлсэн 2 , хэрэгжүүлээгүй 1 байгууллага, Албан шаардлагыг 100 биелүүлсэн 19, 50-80 хувь хэрэгжүүлсэн 6 байгууллага байна. Зөвлөмжийн биелэлтийн хувьд нийт 67 байгууллагад 212 зөвлөмж өгснөөс 199 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 85 хувьтай 10 зөвлөмж, 30-60 хувийн хэрэгжилттэй 3 зөвлөмж.			
81		1.4/. Монгол Улсын 2021 оны төсвийн төслөөс хасагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр	МУ-ын ЗГ-ын 2021 оны Улсын төсвийн төслөөс хасагдсан төсөл, арга хэмжээнүүдийг Сангийн сайдын 2018 оны 12 сарын 25-ны өдрийн 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг үнэлж,	70%	70%	

			ашгийг тооцон эрэмбэлж, төсвийн тухай хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн дараа оны төсвийн төсөлд тусгах асуудлыг шийдвэрлэх;	эрэмбэлэх үйл ажиллагааны журам” журмын 5.1, 5.2, 5.3, 5.4-д зааснаар хөрөнгө оруулалтын саналыг 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор Төсвийн тухай хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн Сангийн яаманд хүргүүлэн ажиллана.			
	82		1.5/. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ЕБС-ийн модон жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох зорилтыг хэрэгжүүлэхээр Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/84 дүгээр тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг ариун цэврийн байгууламжийн орчин үеийн технологийн шийдэлийн судалгаа хийж, 5 төрлийн технологийн шийдлийн зураг, төсөл ажлын даалгаврыг боловсруулж байна. Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн хуралдааны 53 дугаар тэмдэглэлээр 2022 онд багтаан модон жорлон бүхий сургууль, цэцэрлэгийг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хангах ажлыг үе шаттайгаар хийх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгасан. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нийгмийн хариуцлагынхаа хүрээнд энэ асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллахаа албан ёсоор мэдэгдээд байна.	100%	100%	
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
29	83	Сургалтын төрийн сангийн зээлийн ашиглалт, төлөлт,	1.4/. Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр суралцаж төгсөөд эх	Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн “Боловсролын зээлийн сан” байгуулах талаар авах арга	Хугацаа болоогүй / үнэлэх	30%	

	134		1.б.2/. Төрийн ивээлд байх, төсвийн санхүүжилтээр хэрэгжих шинжлэх ухааны салбар, судалгааны чиглэлийг тодорхой болгох, төсвийн санхүүжилтээр хийгдэх судалгааны сонгон шалгаруулалт, ажлын үр дүнг эрдэмтэд, хэрэглэгч, олон нийтэд ил тод, нээлттэй болгох;	“Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгол хийх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулсан. Журмын төсөлд тэргүүлэх чиглэл, цөм технологийг тодорхойлох, тодотгох, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүнд оролцогсдын чиг үүрэг, ажлын хуваарилалт, хариуцлагыг тодорхой болгох зохицуулалт хийсэн. Улсын Их Хурлаар хэлэлцэгдэж байгаа “Шинжлэх ухаан, технологийн тухай хууль”-ийн нэмэлт өөрчлөлт батлагдсаны дараа хуульд нийцүүлэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна. Эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, үндсэн чиглэлийг санхүүжүүлэх аргачлалын төслийг боловсруулсан. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	70%	70%	

			хуулийн төсөл батлагдсанаар энэхүү журмын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулна.			
	135	1.6.4/. Багш, судлаач, эрдэмтдийн бүтээлийн мэдээллийн сан, номын сангийн нэгдсэн сүлжээг бий болгох /БУМС/;	Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем /ДБУМС/-д дээд боловсролын сургалтын байгууллагын Багш, судлаач, эрдэмтдийн эрдэм шинжилгээ, судалгааны бүтээлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагын номын сангийн орчны мэдээллийн нэгдсэн модуль бүхий мэдээллийн санг үүсгэж, жил бүр мэдээллийг шинэчлэн баяжуулан ажиллаж байна.	100%	100%	
	136	1.6.5/. Багш, судлаач, магистр, докторын сургалтад суралцагчдын судалгааны ёс зүйг сайжруулах, бүтээлийн хуулбарлалтыг илрүүлэх системийг бүрдүүлэх;	Засгийн газрын 2018 оны 282 дугаар тогтоолоор батлагдсан “Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 3.1.5 дахь заалтад оюуны бүтээлийн эрхийн хамгаалалтыг сайжруулах, бүтээлийн зөвшөөрөлгүй хуулбарлалтыг шалгах программтай болох замаар судалгааны ёс зүйн талаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах нөхцөлийг бүрдүүлэх”-ээр туссан.	30%	30%	
	137	1.6.6/. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны сэтгүүлд бүтээлээ нийтлүүлж, бүтээл нь дэлхийн хэмжээнд шинжлэх ухааны эргэлтэд орж байгаа эрдэмтдэд дараагийн судалгааны ажилд санхүүгийн дэмжлэг үзүүлдэг болох;	БШУ-ны сайдын 2020 оны 08 дугаар сарын 21-ний А/32 дугаар тушаалаар “Эрдэм шинжилгээний шилдэг өгүүлэл хэвлүүлсэн судлаачийг шалгаруулах, урамшуулал олгох журам” боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Журмын төслийг эцэслэн боловсруулж яамдаас санал авч нэгтгэн Засгийн газарт хүргүүлэхэд бэлэн болсон.	70%	70%	

	138		1.6.7/. Төрийн болон төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн талаар баримтлах бодлогыг тодорхой болгох;	2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” 25 дугаар тогтоолоор Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоолоор “Мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл”-ийг хүчингүй болгосон. Ингэснээр их, дээд сургууль, коллеж нь зөвхөн сургалтын төлбөрөөс санхүүжихээр болсон.	100%	100%	
	139		1.6.8/. Дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, ангилал, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад дүгнэлт өгч, холбогдох арга хэмжээ авах.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/56 дугаар тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус ажлын хэсэг Шихихутуг их сургууль, Улаанбаатар эрдэм их сургууль, Монголын үндэсний их сургууль, “Хүрээ” холбоо мэдээлэл технологийн дээд сургууль, Бурхан шашны дээд сургууль, Соёл-эрдэм дээд сургууль, Монгол дээд сургууль, Түшээ дээд сургууль, Хэл иргэншлийн дээд сургууль, Шинэ иргэншил дээд сургууль, Гурван тамир коллеж, Гүрэн дээд сургууль зэрэг 12 сургалтын байгууллагын Монгол Улсын боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан нийтээр дагаж мөрдөх стандарт, дүрэм журмын хэрэгжилт, мөн 2020-2021 хичээлийн жилийн сургалтын бэлтгэл, элсэлтийн үйл ажиллагаа, сургалтын чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж,	100%	100%	

			мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Үүнд: 1/Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн “Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” А/105 дугаар тушаалаар “Монгол дээд сургууль, А/106 дугаар тушаалаар “Хэл иргэншлийн дээд сургууль”, А/107 дугаар тушаалаар “Шинэ иргэншил дээд сургууль” - ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон. 2/Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн “Мэргэжил /хөтөлбөр/-ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болгох тухай” А/100 дугаар тушаалаар Улаанбаатар эрдэм их сургуулийн 1, Хүрээ мэдээлэл холбоо, технологийн дээд сургуулийн 5, Соёл Эрдэм дээд сургуулийн 1, Түшээ дээд сургуулийн 3, мэргэжил /хөтөлбөр/-ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болгосон.			
	140	1.в.1/. в.Боловсролын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны чиглэлээр: Боловсролын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны талаарх холбогдох хуулийн зохицуулалтын сайжруулах;	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 08 тоот тогтоолоор “Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”, “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”, “Хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага”-ыг тус тус баталсан.	100%	100%	
	141	1.в.2/. Магадлан итгэмжлэх байгууллага, хөтөлбөр магадлан итгэмжлэх байгууллага, Магадлан	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн 2018 оны 08 тоот тогтоолоор “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн магадлан	100%	100%	

		итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн эрх үүргийг холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулан тодорхой болгох;	итгэмжлэх үйл ажиллагааны журам"-ыг баталсан.			
142		1.в.3/. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах;	Европын холбооны "Ерасмус плюс" хөтөлбөрийн хүрээнд Армени, Казакстан, Монгол, Украин улсууд хамтран хэрэгжүүлсэн "3 дугаар түвшний хөтөлбөрийг Европын улсуудын жишигт нийцүүлэн, үйл ажиллагааг сайжруулах замаар судалгааны интернационалчлалыг дэмжих нь" (СЗQA) төслийг хэрэгжүүлсэн. Тус төслийн хүрээнд "Дээд боловсролын 3-р түвшин (доктор)-ий чанарын баталгаажуулалтын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага"-ыг боловсруулсан бөгөөд БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолоор баталсан. Ингэснээр докторын түвшний чанарын баталгаажуулалтын шалгуур шаардлага нь олон улсын түвшинд нийцэх нөхцөл бүрдсэн болно. Мөн тухайн төслийн хүрээнд МУИС-ийн докторын түвшний биологийн сургалтын хөтөлбөр, Отгонтэнгэр их сургуулийн Боловсрол судлалын хөтөлбөр тус тус магадлан итгэмжлэгдсэн.	100%	100%	
143		1.в.4/. Боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагыг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх ажилд дэмжлэг үзүүлэх;	АХБ-ны Дээд боловсролын шинэчлэлийн төслийн хүрээнд Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл ба Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын олон улсын сүлжээ (INQAANE) хамтран "Чанарын дотоод баталгаажуулалт" сэдэвт цахим сургалтыг 2020 оны 5 дугаар сарын 19,	70%	70%	

			20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад төрийн өмчийн 11 их сургууль (МУИС, АШУУИС, МУБИС, ШУТИС, МГАМТИС, СУИС, ХААИС, Дорнод их сургууль, Ховд их сургууль, ДХИС, ҮБХИС), хувийн өмчийн 14 их, дээд сургуулиас (Хүмүүнлэгийн их сургууль, Отгонтэнгэр их сургууль, Технологи, технологийн дээд сургууль, Их засаг олон улсын их сургууль, Олон улсын Улаанбаатарын их сургууль, Сан их сургууль, Шихихутуг их сургууль, Эм Ай Ю дээд сургууль, Билиг дээд сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Сэрүүлэг дээд сургууль, Шинэ иргэншил дээд сургууль, Энэрэл дээд сургууль, Маргад дээд сургууль)-ийн 300 багшийг онлайн оролцуулан зохион байгуулсан. Сургалтаар “Сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаанд чанарын дотоод баталгаажуулалтыг хангах нь” сэдэвт лекц, Тайван, Оросын Холбооны Улс болон Монгол Улсын МУИС болон Хүмүүнлэгийн ухаан их сургуулийн дотоод баталгаажуулалтын арга зүй, туршлагатай тус тус танилцсан.			
	144	1.в.5/. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас Боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллагад олгох санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх.	2021 оны Төсвийн төсөлд санхүүжилтийг нэмэгдүүлэх тооцооллыг хийн, тусгаж явуулсан боловч улсын төсвийн орлого буурсантай холбоотой нэмэгдээгүй. Цаашид нэмэгдүүлэх саналыг тусган ажиллана.	70%	70%	
	145	1.г.1/. г.Боловсролын зээлийн сангийн үйл	Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын	30%	30%	

		ажиллагааны чиглэлээр: оюутны хөгжлийн зээлийг барьцаа хөрөнгөгүйгээр олгоход үүсэх эргэн төлөлтийн эрсдлийг шийдвэрлэх банк, санхүүгийн механизмыг бий болгох, эргэн төлөлт, хуримтлалын хөрөнгөөр төсөвт ачаалалгүй, бие даан хөгжих оюутны хөгжлийн зээлийн сангийн тогтолцоог бий болгох;	сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам"-ыг баталсан.			
	146	1.г.2/. Оюутны хөгжлийн зээлд хамрагдалтыг нэмэгдүүлэх, иргэд, оюутан, суралцагчид тус зээлийн талаар мэдээлэл, сурталчилгаа хийх.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн “Боловсролын зээлийн сангийн талаар авах арга хэмжээний тухай” 70 дугаар тогтоол гаргуулсан. Тус тогтоолын 5 дугаар заалтаар “Журам, чиглэл шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2014 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын 4 дэх хэсэгт “4.1.8. цаатан өрхийн бакалаврын хөтөлбөрт суралцагч.”, “4.1.9. төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад сувилагч мэргэжлээр дээд боловсролын дипломын болон бакалаврын хөтөлбөрт элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтын 501-ээс дээш оноо авсан бол хичээлийн жилийн эхний улирлын сургалтын төлбөрийг 100 хувь; суралцагч 2.5-3.0 хүртэл голч оноотой суралцсан тохиолдолд сургалтын төлбөрийн 70 хувийг, 3.0 болон түүнээс дээш голч оноотой суралцсан	100%	100%	

			тохиолдолд 100 хувь” гэсэн хэсгүүдийг нэмж оруулсан.			
147		3.. Тогтоолын хэрэгжилтийн талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны хуралдаанд 2017 оны намрын чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Л.Энх-Амгалан/-нд тус тус үүрэг болгосугай.	Боловсрол, шинжлэх ухааны яамны эрлэх асуудалд хамаарахгүй тул хяналтаас хасах	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	
148		1.б.1/. б.Засгийн газраас дүрэм, журам, тогтоол гарган хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр: дээд сургуулийн судалгааны чадавх, үр өгөөжийг сайжруулах, үр дүнг нь хөдөлмөрийн зах зээлийн эргэлтэд оруулж инновацийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ бий болгох, өндөр технологийн лабораторийг нийлүүлэх, хамтран ашиглах, судалгаа, шинжилгээний дэд бүтэц, лабораторийн нөхцөл байдлыг үнэлж, хүний нөөц,	2019 оны эхний хагас жилд нийт 1,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 5 багц лабораторийг Их, дээд сургуулиудад Дээд боловсролын шинэчлэл төслөөс нийлүүлсэн. Эдгээр нь сургуулиуд болон судлаачдад дундын зарчмаар ашиглагдана. Тухайн төслөөс нийлүүлэгдсэн лабораториудын талаарх мэдээллийг лаборатори тус бүрээр хийгдэж буй судалгааны чиглэл, төсөл, багш, оюуны тоог гарган Дээд боловсролын шинэчлэл төслийн вэб сайтад байршуулаад байна.	70%	70%	

			байгууллагын чадавх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэлхийн зах зээлд гаргаж улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх чиглэлээр хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;				
36	149	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	2.1.4.. Баян-Өлгий аймаг дахь хэлний цөөнх хүүхдийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг төрийн албан ёсны хэл дээр явуулах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай төсөв, хөрөнгийг шийдвэрлэж, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.	БСШУС-ын яамны ажлын хэсэг тус аймагт ажиллаж, Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжил, арга зүйн ажлын үр дүн, ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтан, багшийн мэргэжлийн бэлтгэл, хичээл, сургалтын үйл ажиллагааг монгол хэлээр зохион байгуулах чадварыг тандан судалж дүгнэлт гаргасан. Энэ дүгнэлтэд үндэслэн Багшийн арга зүйг хос хэлний сургалтын онцлог, заах арга зүйг эзэмших, багш бүр сургалтын идэвхтэй арга барил эзэмших, хөгжүүлэх, Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн, сургалтын менежерүүдээс багшид үзүүлэх онол арга, зүйн дэмжлэгийг нэмэгдүүлэх, бүх судлагдахууны мэргэжилтэн нар өөрийн чиглэлийн багш нарынхаа монгол хэлний мэдлэг, чадвар хэрэглээнд анхаарах, Увс, Ховд аймгуудтай багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж багшаа хөгжүүлэх, Их дээд сургуульд элссэн оюутнуудаа монгол хэлний чадварын түвшнээр хэлний бэлтгэл хөтөлбөрт хамруулах зэрэг зөвлөмжийг өгч хэрэгжилтийг хянан, зөвлөн тусалж ажиллаж байна.	70%	70%	
	150		2.1.5.. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээ үзүүлэх олон	100%	100%	

		эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох эрхийг хангах үүднээс Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг дэх Сувиллын цэцэрлэг, яслийн 10 дугаар цогцолборын барилга байгууламжийг шинэчлэн ашиглалтад оруулах, төсөв, хөрөнгийг шийдвэрлэх.	улсын стандартад нийцсэн орчин нөхцөлтэй ясли, цэцэрлэгийн 10 дугаар цогцолбор 2020-2021 оны хичээлийн жилд ашиглалтад орсон. Тус цэцэрлэг нь сургалтын болон дасгал хөдөлмөрийн танхим, спорт заал, усан бассейн, эмчилгээний хэсэг, тосон бариа, ахуй болон хэл засал, тархины саажилт болон тулгуур эрхтний бэрхшээлтэй хүүхдүүдийг сэргээн засах эмчилгээний хэсэгтэй бөгөөд хүүхдийн хөгжлийн онцлогт үйлчилгээг үзүүлж байна.			
	151	2.1.6.. Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах үүднээс Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн холбогдох заалтыг Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нийцүүлэх.	Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тэгш хамруулан сургах талаар тусган боловсруулсан	70%	70%	
	152	3.13.. Хүний эрх, хүүхдийн эрхийн боловсрол олгох агуулгыг бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлэх.	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт хүний эрх, хүүхдийн эрхийн чиглэлээр тодорхой агуулгыг тусган сурагчдад ойлголт мэдлэгийг олгож байна. Тухайлбал, бага ангийн сургалтын хөтөлбөрт хүүхдийн анги танхим болон сургууль орчиндоо мөрдөх дэг журам, өөрийн болон бусдын болгоомжгүй үйлдлээс үүсдэг осол гэмтлээс сэргийлэх, тээврийн хэрэгслээр аюулгүй зорчиход мөрдөх журам, зорчигчийн үүрэг зэрэг ойлголт мэдлэгийг суралцагчдад өгөх; дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөрт эрхээ хамгаалах, зөрчил үүсэх шалтгаан,	100%	100%	

				зөрчлийн зэрэг, сөрөг тал, үл ойлголцол, зөрчлөөс сэргийлэх арга зам, эрх зүйн харилцаанд оролцоход эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг агуулга судлагдахаар тусгагдсан.			
37	153	Чиглэл өгөх тухай 2018-04-25 Дугаар 2018 №08 ЭЗБХ	1.4/. Монгол Улсын боловсролын салбарт статистикийн үйл ажиллагааг дэмжсэн бодлого хэрэгжүүлж, статистикийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг сургах, давтан сургаж мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох.	Дээд боловсрол, Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн аргачлал, маягт шинэчлэгдэн батлагдсантай холбоотойгоор салбарын статистикийн мэдээ хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан 2 удаагийн онлайн сургалтыг 2020 онд зохион байгуулж ажилласан. Дээд боловсролын удирдлага мэдээллийн систем /ДБУМС/-ийг хариуцсан мэргэжилтнүүдтэй хамтран Их, дээд сургуулиудын статистикийн мэдээ хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулсан цахим уулзалтыг 2020 оны 10-12 сард амжилттай зохион байгууллаа. Сургалтад нийт 85 (97%) их, дээд сургууль, коллежийн 145 мэргэжилтэн, 62 эрдэм шинжилгээний байгууллагын 186 мэргэжилтэн оролцож, сонирхсон асуултаа асууж, мэдээлэл солилцсон.	70%	70%	
	154		2.2/. Төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах;	Дээд боловсролын салбарын маягт болон түүнийг нөхөх заавар шинэчлэн батлагдсан. Үүнд: • Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020-05-07 өдрийн №А/223 дугаар тушаалаар - Үндэсний статистикийн хорооны даргын 2020-03-24 өдрийн №А/30 дугаарын тушаалаар Шинжлэх ухаан, технологийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал, статистикийн мэдээлэл цуглуулах захиргааны болон албан	70%	70%	

				ёсны маягт, түүнийг нөхөх зааврыг Үндэсний статистикийн хорооны АРГА ЗҮЙН БАЙНГЫН ЗӨВЛӨЛ болон ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН хурлаар хэлэлцүүлэн, батлуулсан. Үүнд: • Шинжлэх ухаан технологийн салбарын статистикийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалыг АНХ УДАА боловсруулан, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны 12 сарын 18-ний өдрийн А/69 тоот тушаалаар батлуулан дагаж мөрдсөн. • Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 12 сарын 30-ны өдрийн А/215 дугаар тушаалаар “Шинжлэх ухаан, технологийн салбарын захиргааны статистикийн мэдээний маягт, нөхөх заавар”-ыг баталсан. • Шинжлэх ухаан технологийн салбарын захиргааны болон албан ёсны статистикийн мэдээний маягт (захиргааны 10, албан ёсны 11 маягт), түүнийг нөхөх зааврыг шинэчлэн боловсруулж, Үндэсний статистикийн хорооны даргын 2020 оны 12 сарын 18-ний өдрийн А/71 болон А/72 тоот тушаалаар батлуулан дагаж мөрдсөн. Аргачлал, маягт шинэчлэн батлагдсантай холбоотойгоор 2020 оноос статистикийн мэдээллийг шинээр батлагдсан маягтаар цуглуулж, нэгтгэж, тайлагнах юм. Ингэснээр Төрийн захиргааны төв байгууллагын албан ёсны статистикийн мэдээ, мэдээллийн чанар сайжирч, хамрах хүрээг өргөжүүлэх чухал ач холбогдолтой юм.			
38	155	Төрийн албаны зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны	5.. Олон удаагийн шүүхийн шийдвэртэй яамдууд хүний нөөцийн бодлого алдагдсан асуудлыг засаж, сайжруулах	Боловсрол, шинжлэх ухааны яамны эрхлэх асуудалд хамаарахгүй байх тул хяналтаас хасах	Хугацаа болоогүй / үнэлэх	Хугацаа болоогүй / үнэлэх	

		тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлд үүрэг өгсөн хуралдааны тэмдэглэл 2018-05-01 Дугаар 2018 №07 ТББХ	арга хэмжээг нэн даруй авах;		боломжгүй	боломжгүй	
39	156	Монгол Улсын консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018-05-15 Дугаар 2018 №13 НББСШУБХ	1.1/. Консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/- ийг бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол олгодог шаталсан сургалттай, сургалт-эрдэм шинжилгээний хэв шинжтэй их сургууль болгох, консерваторийн боловсрол эзэмшүүлэх зардлыг төр хариуцдаг байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;	Консерваторийн дээд боловсрол эзэмшүүлэх зардлыг цэрэг, цагдаагийн сургуулийн адил төрөөс хариуцдаг болохоор Боловсролын тухай, Дээд боловсролын тухай хуулиудын үзэл баримтлалын төсөлд тусгаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд явуулсан боловч, “хуулиудын нэмэлт, өөрчлөлтийн төсөл биш шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах нь зүйтэй” гэсэн хариу ирүүлсэн. Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Хууль шинээр батлагдсаны дараа “Дээд боловсролын сургалтын байгууллагын ангилал тогтоох журам”-ын дагуу тус сургуулийг их сургуулийн ангилалд оруулах асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар шийдвэрлэнэ.	70%	70%	
	157		1.2/. Сургалтын тоног төхөөрөмж, сургалтын орчны материаллаг бааз /хөгжмийн зэмсэг, номын сан, лингафоны кабинет	2020 онд Дээд боловсролын шинэчлэлийн төслийн санхүүжилтээр тус бүр 15 сая төгрөгийн 2 акустик төгөлдөр хуур хөгжим нийлүүлсэн. Циркийн тэнхимийн сургалтын үйл ажиллагаанд БСШУС-ын яамны 40 сая	70%	70%	

		зэрэг/-ыг бэхжүүлэх, сургуулийн хичээлийн зориулалтын барилга, байгууламжийн засвар үйлчилгээ, циркийн сургуулийн болон оюутны дотуур байр барих хөрөнгө оруулалтыг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багц болон гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээс жил бүр үе шаттай төсвийн төсөлд тусган хэрэгжүүлэх;	төгрөгийн санхүүжилтээр сургалтын тоног төхөөрөмж нийлүүлсэн.			
	158	1.3/. Консерваторийн бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг сургалтын хөтөлбөр, онцлогтой уялдуулан ялгавартай тогтоож, жил бүр Засгийн гарзын тогтоолд тусган шийдвэрлэж байх;	Консерваторийн бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативын хэмжээг ялгавартай тогтоохоор Засгийн газрын тогтоолын санал боловсруулан яамдаас санал авахаар ажиллаж байна.	30%	30%	
	159	1.4/. Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.4 дэх заалтыг хэрэгжүүлэхэд Консерватори /хөгжмийн	Улсын төсөвт жил бүр санхүүжилтийг тусган батлуулдаг бөгөөд Консерваторийн сургалтын онцлогт тулгуурлан санхүүжилтийг төсөвлөн тусгай статусаар үйл ажиллагааг явуулж байна. 2020 онд 1000 гаруй суралцагчтай үйл ажиллагаа явуулж, 4797,4 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.	100%	100%	

		дээд боловсролын байгууллага/-д дэмжлэг, туслалцаа үзүүлэх;	2021 онд 1077 суралцагчидтай үйл ажиллагаа явуулах бөгөөд сургуулийн төсөв 5.1 тэрбум төгрөгөөр батлагдаад байна.			
	160	1.5/. Консерваторийн залуу багш нарыг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлэх, магистр, докторын сургалтад Боловсролын зээлийн сан, Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд тэтгэлэгт хамруулах болон багш, оюутныг олон улсын ижил түвшний консерваторид туршлага судлах, солилцоонд хамрагдах, гадаадаас багш, мэргэжилтэн урьж ажиллуулах талаар тусгайлсан хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлэх;	Германы Эрдэмтэн Солилцооны байгууллага (DAAD)-ын санхүүжилтээр ISAP төсөл 2019 оноос хэрэгжиж байна. Тус төсөл нь 88,400 еврогийн санхүүжилттэй бөгөөд тус сургуулийн 10 багш, 10 оюутан хамрагдаж байгаа болно.	70%	70%	
	161	2.. Энэ тогтоолын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд 2018 оны 10 дугаар сарын 01-ний дотор танилцуулахыг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т, жил бүр биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн	2018 онд танилцуулагдсан	100%	100%	

			бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо /Ё.Баатарбилэг/-нд тус тус даалгасугай.				
40	162	Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2018-12-20 Дугаар 2018 №24 НББСШУБХ	1.4/. Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хэрэгжүүлэх хүрээнд хүүхдийн сургууль, цэцэрлэг, дотуур байр, нийтийн эзэмшлийн зам, талбай, орон сууц болон гэр хороолол дахь гадаад, дотоод орчны аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, орчны нэгдсэн стандартыг баталж мөрдүүлэх;	Монгол Улсын стандарт MNS 6782:2019 “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”, Монгол Улсын стандарт MNS 6781:2019 “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага”, Монгол Улсын стандарт “Сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага”-ыг батлуулсан. Стандарт нь сургалтын байгууллагын гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг багш, ажилчид, сурагч, эцэг эхийн оролцоотой үнэлж, аливаа болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг амжилттай сурч хөгжих орчин нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн.	100%	100%	
	163		1.11/. Архи, тамхи, согтууруулах ундаагаар үйлчилдэг болон худалдан борлуулдаг цэгүүдийг сургуулийн ойр орчинд ажиллуулахгүй байх хуулийн хэрэгжилтийг хангуулж, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол, хүнсний хангамжийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах талаар холбогдох байгууллагын хяналтыг сайжруулах;	Боловсрол, шинжлэх ухааны сайдаар ахлуулсан тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Шадар Сайдын ажлын алба, МХЕГ, ОБЕГ, СЯ, ЭМЯ, ХНХЯ, ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн төлөөллүүд орж ажилласан юм. Ажлын хэсгээс, Монгол Улсын Шадар Сайдын 02 тоот “Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай” албан даалгавар, БШУС-ын А/17 тоот “Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” тушаал, Шадар сайд болон Сангийн яам, ХНХЯ, БШУЯ, ЭМЯ-ны сайдуудын “Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэх зарим арга хэмжээний тухай” хамтарсан	100%	100%	

				тушаал, МХЕГ-ын даргын “Хичээл, сургалтын үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбогдуулан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх чиглэл өгөх тухай” албан даалгавар гарсан. Энэ хүрээнд Мэргэжлийн хяналтын байгууллагаас төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж дүгнэлт гаргасан.			
41	164	Экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019 №04 ЭЗБХ	1.4/. Олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай, мэдлэг, инноваци шингэсэн хөдөө аж ахуй, мэдээллийн технологи, аялал жуулчлал болон бусад салбарыг хувийн хэвшилд тулгуурлан хөгжүүлэх бодлого, стратегийг танилцуулах;	Боловсрол, шинжлэх ухааны яамны эрхлэх асуудалд хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	
42	165	Чиглэл өгөх тухай 2019-06-05 Дугаар 2019_05 "Цахим бодлогын түр хороо"	1.9/. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 25/16 дугаар зөвлөмжийн хэрэгжилтийг Цахим бодлогын түр хороонд 2019 оны 6 дугаар сарын 15-ны дотор танилцуулах;	Инноваци цахим бодлогын байнгын хорооны 2020 оны 08 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулсан “Боловсролын салбар дахь цахим шилжилт” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулсан. уг хэлэлцүүлэгт Боловсролын салбарт хэрэгжиж буй мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүний биелэлтийг танилцуулж, дунд хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй ажлыг танилцуулсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан гарсан.	100%	100%	
	166		1.10/. Үндэсний эв нэгдэл, язгуур ашиг сонирхолд харшлах цахим орчин, цахим орчин дахь нийгмийн сүлжээний сөрөг	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Цахим бичвэр, цахим хэл шинжлэлийг хөгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулахаар тусган, хэрэгжилтийг хангах чиглэлээр ажиллаж эхлээд байна.	70%	70%	

			мэдээллээс иргэдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор цахим орчин, цахим орчин дахь нийгмийн сүлжээний зөв зохистой хэрэглээг сурталчлах, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бүх нийтийн тоон бичиг үсгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх тодорхой төсөл, арга хэмжээг төлөвлөн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020-2022 онуудад хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, хэрэгжилтийг эрчимжүүлэх;				
Ерөнхийлөгчийн зарлиг							
43	167	Хадны зураг, бичээсийг хамгаалах, судлах ажлыг дэмжих тухай 2017-07-09 Дугаар 2017_181	1.. Өвөг дээдсийн хаданд мөнхөлсөн хосгүй гайхамшигт чулуун судар, түүх, соёл, урлагийн нандин өв: хадны зураг, бичээсийг хадгалан хамгаалах, судлан шинжлэх талаар эрдэмтэн судлаачид, иргэд, байгууллагаас гаргаж буй санал, санаачилгыг дэмжих ЗОРИЛГООР, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай				

			хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь: 1.Хил дамнасан соёлын өв, түүний дотор хадны зураг, бичээсийг судлах зорилгоор олон улсын хамтарсан судалгааны баг байгуулж ажиллах; Хадны зураг, бичээсийн олон улсын эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн-“Хадны зураг, бичээсийн чуулган”-ыг хоёр жил тутамд нэг удаа Дэлхийн өвийн өдрийг тохиолдуулан зохион байгуулж байхыг Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шинжлэх Ухааны Академид даалгасугай.				
44	168	Нутаг орны газар зүйн нэрийг хамгаалах тухай 2017-07-10 Дугаар 2017_186	1.. Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГБОЛГОХ нь: 1. Монгол Улсын Их Хурлын 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 42 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын нутаг				

			дэвсгэрийн газар зүйн нэрийн жагсаалт” дахь газар усны газар зүйн нэрийг албан хэрэг, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд мөрдүүлэх, тухайн орон нутагтаа ард иргэдийн дунд сэргээн хэвшүүлэх, цаашид хууль бусаар газар орны нэр өөрчлөх гэмт явдалтай хууль тогтоомжийн дагуу тууштай тэмцэхийг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай. 2. Уул ус, газар нутгаа эрх бүхий байгууллагаас баталсан нэрээр зөв нэрлэж занших, өөрчлөн буруу нэршихээс сэргийлэх, монгол хэлнээс бусад хэлээр орчуулах буюу бусад хэлний дуудлагаар галиглахгүй байхыг Монгол Улсын нийт иргэд, байгууллагад уриалсугай.				
45	169	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46	1.. Монгол бичгийн цахим кодыг хэрэглэх үндэсний стандартыг холбогдох мэргэжилтнүүдийн саналыг тусган шуурхай боловсруулж, хуульд заасны дагуу батлуулах, цаашид хөгжүүлэн тогтвортой байдлыг хангаж, цахим орчинд үнэдсний хэрэглээг нэмэгдүүлэх				

		талаар бодлого, төлөвлөгөө гарган ажиллахыг Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Монгол хэлний тухай хуулиар үүрэг хүлээсэн эрх бүхий судалгааны байгууллагад; Үндэсний стандартыг боловсруулах ажилд хяналт тавьж, боловсруулсан стандартыг судалж батлах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, монгол бичгийн цахим кодчиллыг олон улсын стандартад үнэдсний стандартыг хэлэлцүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулахыг Стандартчилал, тохирлын үнэлгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Монгол Улсын Шадар сайдад чиглэл болгосугай.				
	170	2.. Монгол бичгийн дунд болон урт хугацааны үнэдсний хөтөлбөрийг боловсруулан баталж, 2018 багтаан хэрэгжүүлж эхлэх; бүх шатны боловсролын сургалтын байгууллагын суралцагч хичээлийн	• Монгол хэл, бичгийн сургалтын хөтөлбөрийг сайжруулан боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/492 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар батлуулж, 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын нийт сургуулийн суралцагчид судалж эхэлсэн. • 1-12 дугаар ангид монгол	100%	100%	

			хөтөлбөрөөр монгол хэл, бичгийн хичээлийг судлахдаа цахим орчинд монгол бичгийг ашиглах, бичвэр боловсруулах бүрэн чадамжтай болж төгсдөг байх; монгол бичгийн хичээлээр улсын төрөлжсөн олимпиадыг зохион байгуулж хэвших; элсэлтийн ерөнхий шалгалт өгөх иргэнээс заавал авах монгол хэл, бичгийн шалгалтанд босго оноо тогтоох; монгол хэл, бичгийн хичээлийг үр бүтээлтэй заан сургаж, амжилт гаргаж буй багш нарыг урамшуулж ажиллахыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад үүрэг болгосугай.	хэл, бичгийн хичээл зааж буй бүх багш нарт зориулсан “Сайжруулсан сургалтын хөтөлбөрийн арга зүй” сэдэвт сургалтыг улс орон даяар зохион байгуулж, багш нарт зориулсан арга зүйн зөвлөмж бичиж, хэвлэн түгээлээ. • Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” 2019 оны А/491 дүгээр тушаалаар 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн 10-12 дугаар ангийн “Монгол бичиг” хичээлийн цагийг тус бүр 35 цагаар нэмэгдүүлж, анги тус бүрд нийт 70 цагаар судлах эрх зүйн орчныг бүрдүүллээ. • Монгол Улсын Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2020 оны 96 дугаар тогтоолоор “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III” түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлагдлаа. Үндэсний хөтөлбөрт монгол бичгийн кодчиллол, стандартыг боловсронгуй болгох, суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан монгол бичгийн сурах бичиг, толь бичиг, сургалтын бусад хэрэглэгдэхүүнийг шинэлэг арга зүйгээр боловсруулж гаргах, цахим хичээл, цахим сурах бичиг, толь бичиг, сургалтын хэрэгсэл боловсруулж, нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагаа тусгагдлаа. • “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг хэрэгжүүлэх ажлыг буюу монгол бичгийн хичээлийн чанарыг дээшлүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, уялдуулан зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Монгол бичгийн үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2020 оны 77 дугаар Захирамжаар батлуулан ажиллаж байна.			
--	--	--	--	---	--	--	--

	171		3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	Монгол Улсын Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 2020 оны 96 дугаар тогтоолоор батдагдсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III” түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосон.	70%	70%	
	172		4.. Энэхүү зарлигт дурдсан ажлуудад болон монгол хэл, бичиг үсгээ сурч судлах, өвлөх, өвлүүлэх, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гарган ажиллахыг иргэд, олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллагуудад уриалсугай.	Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”-ыг 2020-2024 онд хэрэгжүүлэх баталсан. Хөтөлбөрийг монгол бичгийн хэрэглээний орчныг бүрэн бүрдүүлэх, монгол бичигт сургах ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнд хүргэх, албан хэргийг кирилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид монгол бичигт бүрэн шилжих эрх зүй, технологийн орчин бүрдүүлж, бэлтгэл хангах, монгол бичгийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлж байна. Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн дэргэд хүний	100%	100%	

				нэрийг үндэсний бичгээр зөв бичих зарчим боловсруулах ажлын хэсэгт ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн хамтран ажилласан. Мөн “Монгол хэлний тухай хууль”, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр - III”-ын хүрээнд 2019-2020 оны хичээлийн жилд ЕБС төгсөх ангийн сурагчдын 15000 гаруй нэрийг, нийт 24000 хүний нэрийг үндэсний бичгээр бичих, засан жигдлэх ажлыг гүйцэтгэсэн.			
46	173	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.16.. Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулиудын ойр орчмын түргэн хоолны болон түргэн үйлчилгээний цэгт хяналт тавих	Боловсрол, шинжлэх ухааны яамны чиг үүрэгт хамаарахгүй тул хяналтаас хасах	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хариуцан хэрэгжүүлэх байгууллагатай хамтран хэрэгжүүлэх нь зүйтэй
ҮАБЗ-ийн зөвлөмж							
47	174	Биоаюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 2011-07-07 Дугаар 2011_25/24	6. Молекул биологи, биоанагаах, биотехнологи, нано технологийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, тэдгээрт ажлын байрыг бодлогоор бий болгох	"Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 3 удгаар сарын 18-ны өдрийн ""Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай"" 95 дугаар тогтоолоор баталсан ""Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл (2020-2025)-ийн 3 дугаарт Биотехнологи/үйлдвэрлэлийн технологи гэж тусгасан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн "Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/308 дугаар тушаалаар Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх дипломын, бакалавр, магистр, докторын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/, индексд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан. Үүнд: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны "Тушаалын хавсралтад	100%	70%	Үр дүнг нэмэгдүүлэх

				нэмэлт өөрчлөлт оруулах тухай" А/52 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх магистр, докторын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр/, индексийн нэмэлт өөрчлөлт"-д 0788 инженерчлэл чиглэлийн хүрээнд 07880210 Биотехнологийн үйлдвэрлэлийн удирдлага мэргэжлийн хөтөлбөрийн индексийг, мөн "Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх дипломын мэргэжлийн чиглэл /хөтөлбөр, индекс"-ийн нэмэлт өөрчлөлтөөр 0914 Анагаах ухааны оношилгоо ба эмчилгээний технологи чиглэлийн хүрээнд 091401 "Лабораторийн техникч"-ийн индексийг тус тус шинээр батлуулсан.			
48	175	Үндэсний эв нэгдэл, язгуур ашиг сонирхлыг дээдлэн бэхжүүлэх тухай 2017-06-20 Дугаар 2017_17/13	3.2.. Үндэсний хэв шинжийг бүрдүүлэх талаар төр, нийгэм, улс төр, соёл, боловсрол, эрдэм шинжилгээ, хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагаа болон иргэдийн оролцоог нэгтгэн чиглүүлсэн үндэсний хөтөлбөр боловсруулан батлан хэрэгжүүлэх	1. Монгол үндэстэн оршин тогтнох соёл, сэтгэлгээний баталгаа болсон монгол бичгээ сурч эзэмших, судлан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хамгаалах, өвлүүлэх, хөгжүүлэх нь Монгол хүн бүрийн төдийгүй дэлхийн бичиг соёлын өв сангийн өмнө монголчуудын хүлээж байгаа эрхэм үүрэг хэмээн үзэж, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар тогтоолоор “Монгол бичиг үндэсний хөтөлбөр III”-ыг батлуулан хэрэгжүүлж байна. 2 “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг баримт бичиг тус бүрд тусгагдсан “Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд: бага, дунд боловсролын сургалтын	100%	70%	Үр дүнг нэмэгдүүлэх

				хөтөлбөр, агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний хөгжил, төлөвшил, хос хэл, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөн батлуулсан. 3. Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө (2021-2030)-д: СӨБ, БДБ-ын сургалтын цөм хөтөлбөрийн агуулгыг Монгол хүүхдийг төлөвшүүлэх, хэл, түүх, хэл соёл, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулах, сайжруулах арга хэмжээг тусган хэрэгжүүлж эхлээд байна.			
49	176	Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай 2017-07-19 Дугаар 2017_19/5	1.. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах	Боловсрол, шинжлэх ухааны яам нь Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг дагалдан Монгол улсын Засгийн газар, Сангийн яам, холбогдох бусад байгууллагуудаас гаргасан дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. Дээрх хууль тогтоомж, дүрэм журам нь Монгол улсын хувьд Мөнгө угаахтай тэмцэх олон улсын байгууллагуудын өмнө хүлээсэн үүрэгт нийцсэн байдаг. Мөнгө угаах болон терроризмтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, холбогдох бусад эрх зүйн хүрээнд боловсрол, шинжлэх ухааны салбарын байгууллагуудын бүх шатанд санхүүгийн ажилтнуудын хараат бус байдлыг хангах зарчмыг баримтлан ажиллаж байна. Үүнд шинээр томилогдох нягтлан бодогч нарыг Төсвийн ерөнхий болон ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлагыг хангасан мэргэжилтнээр, төсөв санхүүгийн бусад ажилтныг Төрийн албаны тухай хуульд заасан шаардлагыг хангасан мэргэшсэн	100%	100%	

				мэргэжилтнийг сонгон шалгаруулж ажиллуулж байна. Мөн салбарын төсөв санхүүгийн ажилтан, нягтлан бодогч нарын хууль эрх зүйн мэдлэг чадварыг тогтмол дээшлүүлэх, чадавхжуулах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Дотоод аудитын нэгж нь харьяа байгууллагад санхүүгийн болон холбогдох дотоод аудит хийхдээ Нягтлан бодох бүртгэлийн хуулийн хэрэгжилттэй хамтатган мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж ажилладаг болно. Салбарын харьяа байгууллагууд болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн нэгжүүдийн бүх мөнгөн гүйлгээ Монгол улсын сангийн яамны Төрийн сан дахь дансаар дамжин, хянагдаж байдаг.			
50	177	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05	1.10. Ерөнхий боловсролын ахлах ангийн сургалтын хөтөлбөрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг ойлгуулан таниулах арга бүхий хичээлийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн тусган хэрэгжүүлэх.	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/467 дугаар тушаалаар 6-12 дугаар ангийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг батлан ерөнхий боловсролын нийт сургуульд хэрэгжүүлж эхэлсэн. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр нь суралцагчид насан туршийн эрүүл амьдралын хэв маягийн талаарх хувь хүний хариуцлагыг ухамсарлан, өөрийн болон бусдын, цаашлаад хүрээлэн буй орчныхоо эрүүл байдлыг хүндэтгэх хандлагыг хөгжүүлэхэд тусална. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр дараах 6 үндсэн агуулгаас бүрдэж байна. Үүнд: 1. Хувийн ариун цэвэр, орчны эрүүл ахуй 2. Хооллолт, хөдөлгөөн 3. Сэтгэцийн эрүүл мэнд 4. Хорт зуршил 5. Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд 6. Осол гэмтэл зэрэг болно. Эрүүл	100%	70%	Үр дүнг нэмэгдүүлэх

				мэндийн хичээл заах багш нарыг давтан бэлтгэж, тэдэнд сургалтын хөтөлбөр, зөвлөмжийг 7000 ширхэг хэвлэж түгээх ажлыг хэрэгжүүлсэн. Ахлах ангийн Нийгмийн ухааны сургалтын хөтөлбөрт хувь хүн ба нийгэм, иргэний эрх зүйн харилцаа, шударга ёс, үл ялгаварлан гадуурхах, эрх зүйн зөрчил ба хариуцлага зэрэг агуулгыг тусган хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ойлгон таниулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.			
51	178	Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын талаар авах арга хэмжээний тухай 2020-11-13 Дугаар 2020_26/16	1. Дэлхий нийтэд тархаад байгаа коронавируст халдвар /Коюид-19/-ын цар тахал иргэдийн дунд илэрч, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан гамшгийн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирлын хэмжээг бууруулах, цар тахлын халдварын тархалтыг зогсоох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээг шуурхай зохион байгуулах.	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгах тухай 181 дүгээр тогтоолуудаар өгсөн үүрэг, чиглэлийн дагуу "Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн "Хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай" А/146 тушаал, мөн А/151 дүгээр тушаалыг батлан хэрэгжүүлснээр бүх шатны боловсролын байгууллагын танхимын сургалтын үйл ажиллагааг түр зогсоож, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг теле болон цахим хичээл хэлбэрээр тасралтгүй зохион байгуулж байна. Мөн их, дээд сургуулиуд цахим хэлбэрээр хичээл сургалтын үйл ажиллагааг тасралтгүй явуулах зохион байгуулалт хийн ажиллаж байна. Бүх нийтийн хөл хориог тогтоосон үед дотуур байранд амьдарч байгаа оюутнуудын суралцаж буй сургууль, орон нутгийн харьяалал болон бусад нарийвчилсан судалгааг гаргаж 71 дотуур байранд амьдарч байгаа 10,541 оюутанд өдөрт дунджаар 5,020 төгрөг, дотуур байранд ариутгал	100%	100%	

				халдваргүйтгэлийг 3 удаа хийлгэхээр тооцож Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн “Дотуур байрны оюутны хоол хүнс, ариутгал, халдваргүйтгэлийн санхүүжилтийн тухай” А/153 тоот тушаалаар 764,5 сая төгрөгийн санхүүжилтийг батлуулж, 2 үе шаттай олгохоор хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд салбарын харьяа байгууллагуудын зайлшгүй шаардлагатай санхүүжилтийн тасралтгүй байдлыг хангаж, багш ажилтны цалин олголт, хувийн өмчийн сургууль, цэцэрлэгт олгох татаас, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлбөрийг цаг хугацаанд нь олгож, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, иргэдийн орлогыг бууруулахгүй байх зорилгыг хэрэгжүүлж байна.			
ЗГ-ын тогтоол							
52	179	Монгол улсын 2018 оны төсвийн тухай хууль, нийгмийн даатгалын сангийн 2018 оны Төсвийн тухай хууль, эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах	5.. “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөр хэрэгжүүлж, анги дүүргэлт хэт өндөр байгаа сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулах, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 2018 оны 2 дугаар сард багтаан хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэгчийг	Монгол Улсын 2018 оны улсын төсвийн тухай хуулиар 105 цэцэрлэг шинээр барихад зориулж 72.5 тэрбум төгрөг батлагдсан үүнээс 2018 онд ашиглалтад орох 18.8 тэрбум төгрөгийн өртөг бүхий 27 цэцэрлэг батлагдсан бол 2965 хүүхдийн хүчин чадалтай 22 цэцэрлэг ашиглалтад орж 81.5 хувийн хэрэгжилттэй байна. Эдгээрээс 2018 онд 12 цэцэрлэг ашиглалтад орж, 2019 онд 7 цэцэрлэг нь ашиглалтад орсон. Улаанбаатар хотод 2016-2017 оны хичээлийн жилд 31 сургууль, 2017-2018 оны хичээлийн жилд 23	100%	100%	

		арга хэмжээний тухай 2017-12-13 Дугаар 2017_337	сонгон шалгаруулж, 2018 онд ашиглалтад оруулах сургууль, цэцэрлэгийн барилгыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, аймаг, нийслэлийн Засаг дарга, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай.	сургууль, 2018-2019 оны хичээлийн жилд 20 ерөнхий боловсролын сургууль 3 ээлжээр хичээллэж байгаа бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилд 3 ээлжээр хичээллэж буй бүх сургуулийг 2 ээлжид шилжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна. Монгол Улсын хэмжээнд 2-5 насны сургуулийн өмнөх боловсролын 312,802 хүүхэд байгаагаас 2019-2020 оны хичээлийн жилд нийт 1,439 цэцэрлэгт 263,333 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 84,2 хувьд хүрч, өмнөх оноос 2,3 хувиар өссөн дүнтэй байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд сургуулийн өмнөх боловсролын салбарт 20990 хүүхдийн хүчин чадалтай 145 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс: 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1120 хүүхдийн хүчин чадалтай 8 цэцэрлэг ашиглалтад орсноос Улаанбаатар хотод 620 хүүхдийн хүчин чадалтай 3 цэцэрлэг, орон нутагт 500 хүүхдийн хүчин чадалтай 5 цэцэрлэг тус тус байна. 2020 онд барилга угсралтын ажил үргэлжилж байгаа 80-95 хувийн гүйцэтгэлтэй 25 цэцэрлэг байна.			
53	180	Аргачлал шинэчлэн батлах тухай “Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал” 2018-01-24 Дугаар 2018_20	4.. Хөгжлийн индексийн үр дүнг салбарын болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлт боловсруулахад ашиглаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, тухайн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн төсөвт олгох хөрөнгийг хөгжлийн индекс ашиглан тодорхойлсон	Монгол улсын Засгийн газрын “хувьсах зардлын дундаж норматив, санхүүжүүлэх аргачлал батлах тухай” 2016 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 242 дугаар тогтоолыг үндэслэн баг, сум, аймгийн төв, нийслэлд үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хувьсах зардлыг байршлаас хамааруулан өөр байхаар тогтоож байгаа болно.	70%	70%	

			итгэлцүүрийг үндэслэн тооцож байхыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус даалгасугай.				
76	212	Жагсаалт батлах тухай 2020-01-22 Дугаар 2020_21	3.. Худалдан авах ажиллагааг (tender.gov.mn) цахим системээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүн, гэрээг тухай бүр цахим системд нийтэлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт болон Төрийн худалдан авах ажиллагааны газарт үүрэг болгосугай.	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт шинээр хэрэгжүүлэх төсөвт өртөг 1,069,904.7 сая төгрөг, санхүүжих дүн 320,871.3 сая төгрөгийн 362 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ батлагдсан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд бөгөөд төсвийн Ерөнхийлөн захирагч 2020 онд Улсын төсвийн хөрөнгөө оруулалтаар салбарын хэмжээнд шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ерөнхий төлөвлөгөөг боловсруулан БСШУС-ын сайдын 2020 оны 12 дугаар сарын	100%	100%	Дотоод хяналтандаа авч ЗГХШМС-ийн хяналтаас хасуулах

				17-ны өдрийн А/811 дугаар тушаалаар баталж “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх заалтын дагуу төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Сангийн яаманд хүргүүлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд бөгөөд төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2020 худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг www.tender.gov.mn, яамны www.meds.gov.mn байршуулж өдөр тутмын сонинд нийтэлсэн. Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд шинээр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны зохион байгуулалт төрийн худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn нэгдсэн систем цахимаар 100 хувь зохион байгуулагдаж, урилга, тендерийн баримт бичиг, зураг төсөв, техникийн тодорхойлолт, үр дүн, гэрээг www.tender.gov.mn, www.meds.gov.mn, www.shilendans.gov.mn тухай бүр нийтлэн ил тод байдлыг ханган ажиллаж байна.			
77	213	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 2020-02-12 Дугаар 2020_62	3.. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4-т заасан арга хэмжээг “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”-ийн дагуу хэрэгжүүлж ажиллахыг гамшгаас	Засгийн газрын 2020 оны 30, 64 дүгээр тогтоол, УОК-ын 2020 оны 1 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн БСШУС-ын сайдын 2020 оны А/43 дугаар тушаалаар 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл улс орон даяар бүх шатны цэцэрлэг, сургууль, их, дээд сургууль, соёл, урлаг, спорт шинжлэх ухааны байгууллагуудын үйл ажиллагааг бүрэн	100%	100%	

			хамгаалах алба, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.	зогсоосон.			
78	214	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 2020-02-19 Дугаар 2020_64	2.. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан энэ тогтоолын 1-д заасан хугацаанд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай: 2.1. цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагааг түр зогсоох хугацаанд хүүхдийн хоол, үдийн цайны зардлаас хэмнэгдсэн хөрөнгийг бямба гарагт хичээллэх багш, ажилтны цалин хөлс болон тухайн байгууллагад ариутгал, халдваргүйтгэлийн материал худалдан авахад зарцуулах; 2.2. ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан теле хичээлийг үргэлжлүүлэх, багш нарын 1, 5, 10 дахь жилийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг онлайн хэлбэрээр зохион	Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын нөхцөл байдлын улмаас улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын сургалтын үйл ажиллагааг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд ажлын 42 хоног /хуанлийн 60 хоног/ түр зогсоосон. Энэ хугацаанд цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмнэлт 42,246.9 сая төгрөгийн тооцоо гарсан. Хэмнэлтийн зардлаар дараах үйл ажиллагааг санхүүжүүлсэн. □ 2020 оны 4 ба 5 дугаар сарын бямба гарагуудад нөхөж хичээллүүлэхээр шийдвэрлэсний дагуу Улсын хэмжээнд ажиллах ЕБС-ийн 31837 багш, 20582 багш бус ажилтны цалингийн зардал 24,279.9 сая төгрөгийн. □ Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын хичээлийг олон нийтийн телевизүүдээр сурагчдад заах теле хичээлийн зардлын тооцоолол хийж 218,283.0 мянган төгрөгийг зарцуулах тухай Сайдын 2020 оны А/52, А/82, А/116 дугаар тушаал батлагдав. □ Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхээр ариутгал халдваргүйтгэлийн зардалд 500.9 сая төгрөг зарцуулах тооцоо. □ Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх сургалтыг теле хэлбэрээр зохион байгуулах зардалд 210,000.0 мянган төгрөгийн тооцоо гарч, БСШУС-ын сайдын	100%	100%	

			байгуулахад шаардагдах зардлыг батлагдсан төсөвтөө зохицуулалт хийж шийдвэрлэх.	A/106 дугаар тушаал гарсан.			
79	215	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай 2020-02-28 Дугаар 2020_78	8.. Энэ онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан шуурхай зохион байгуулж, мэдээллийг ил тод нийтэлж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 100 хувь төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn урилга, нээлтийн мэдээ, үр дүн, гэрээний мэдээллийг оруулж ил тод байдлыг ханган ажиллаа. Салбарын хэмжээнд 2020 оны төсвийн хөрөнгөөр шинээр хэрэгжихээр төлөвлөсөн худалдан авах ажиллагааны зохион байгуулалт хэрэгжилтийн үр дүн дараах явцтай байна: Үүнд: Худалдан авах ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт 21 аймаг 235 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас 232 төсөл, арга хэмжээний тендерийг зарлаж, 218 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, нийслэлийн Засаг даргын тамгын газар 26 төсөл арга хэмжээнээс 26 төсөл, арга хэмжээний тендерийг зарлаж, 24 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны газар 67 төсөл арга хэмжээ зохион байгуулахаас 58 төсөл, арга хэмжээний тендерийг зарлаж, 53 төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллав. БСШУСЯ 45 төсөл, арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөр Соёлын яам, Бие тамир, спортын улсын хороонд 2020 оны эхний хагас жилийн байдлаар тус байгууллагуудын эрхлэх асуудлын 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа	100%	100%	

				зохион байгуулагдаагүй хүлээгдэж байсан тул тус байгууллагууд руу шилжүүлсэн. Тус яам шинэ бүтцээр 38 төсөл, арга хэмжээний хэрэгжихээр төлөвлөгдөж 38 тендерийг зарлаж, 38 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан. Харьяа байгууллагууд 9 төсөл, арга хэмжээ зохион байгуулахаас 9 төсөл, арга хэмжээний тендер зарлаж, 9 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан гүйцэтгэлтэй байна. Салбарын хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, гэрээ байгуулах ажил 372 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зохион байгуулахаас 363 төсөл арга хэмжээний тендерийг зарлаж, гэрээ байгуулалт 344 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан ажиллав.			
80	216	Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай 2020-03-18 Дугаар 2020_95	2. Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийг улсын төсөв, бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар нарт тус тус үүрэг болгосугай.	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн дагуу батлагдсан Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцаас хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний 2021 оны төсвийн хуваарилалтад инноваци, өндөр технологийн чиглэлээр гүйцэтгэх ажлуудад 2 тэрбум төгрөг тусгагдсан. Уг санхүүжилтээр шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, бүтээгдэхүүн, үйлчилгээ болгон хэрэглээнд нэвтрүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, инновацийн тэргүүлэх, салбар, чиглэлд хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, хамтын ажиллагаа, түншлэлийг өргөжүүлэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийх ажилд дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг гүйцэтгэхээр	70%	70%	

				төлөвлөсөн болно.			
	217		3. Тэргүүлэх чиглэлд тусгагдсан инновацийн үйл ажиллагааны арга хэмжээг өөрсдийн үйл ажиллагааны жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, тухайн арга хэмжээнд батлагдсан төсөвт эх үүсвэрийн дүнд багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын "Инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл батлах тухай" 2020 оны 95 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, тэргүүлэх чиглэлийн хүрээнд инновацийн үйл ажиллагааны арга хэмжээг өөрсдийн үйл ажиллагааны жил бүрийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, тухайн аймаг, орон нутгийн төсөвт багтаан хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт чиглэл өгч ажиллалаа. Боловсрол, шинжлэх ухааны сайдын аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулах 2021 оны гүйцэтгэлийн гэрээний төсөлд шинжлэх ухаан, инновацийн чиглэлээр гүйцэтгэх ажлуудыг тусгуулах арга хэмжээ авч ажилласан.	70%	70%	
81	218	Эрүүл мэндийн сургалт, эрдэм шинжилгээний зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай 2020-03-18 Дугаар 2020_98	2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн сургалтын үйл ажиллагааны зардлыг тус сургуулийн төсвөөс санхүүжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний зардлыг тохиолдолд суурилсан төлбөрийн аргаар холбогдох хуульд заасны дагуу санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн сайд	Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байсан АШУҮИС-ийг БСШУС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх, үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх, байгууллагын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг шилжүүлж авах тухай Засгийн газрын 98 тоот тогтоол гарсан. Энэ дагуу тус эмнэлгийн 2020 оны үйл ажиллагааны зардалд шаардлагатай 8.0 тэрбум төгрөгийг Нийслэлийн харьяа цэцэрлэгийн тусгай зориулалтын шилжүүлгийн хэмнэгдэж буй зардлаас гаргах төсвийн зохицуулалт хийх тухай БСШУС-ын сайдын 3 сарын 26-ны өдрийн 1а/1759 тоот албан бичгийг Сангийн сайдад хүргүүлж, шийдвэрлэлээ.	100%	100%	

		Д.Сарангэрэлд, эмнэлгийн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах эрхийг төсвийн шууд захирагчид олгохыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт тус тус даалгасугай.				
	219	3. Шинэ коронавирус (COVID-19)-ийн цар тахалтай тэмцэх, халдвараас урьдчилан сэргийлж өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан боловсролын салбарын багш, албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, хэвтүүлэн эмчлэх бэлтгэл ажлыг шуурхай хангах зорилгоор нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хуваарилсан тусгай зориулалттай зардлын хэмнэлтийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлэгт шилжүүлэн зарцуулах зохицуулалтын арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, нийслэлийн Засаг дарга С.Амарсайхан	Шинэ төрлийн коронавирусийн тархалтын улмаас улсын хэмжээнд ЕБС болон СӨБ-ын сургалтын үйл ажиллагааг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд ажлын 65 өдөр /хуанлийн 91 хоног/ түр зогсоох шийдвэрийг Улсын онцгой комиссоос гаргасан. Энэ хугацаанд цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоолны зардлын хэмнэлт 65,114.8 сая төгрөгийн тооцоо гарсан. Хэмнэлтийн зардлаар дараах үйл ажиллагааг санхүүжүүлэхээр тооцож байна. - Улсын хэмжээнд 2020 оны 5 ба 6 дугаар сард ерөнхий боловсролын сургуулийн 31837 багш, 20582 багш бус ажилтны илүү цагийн цалин хөлсөнд 21,244.9 сая төгрөгийн зардал, - Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхээр ариутгал халдваргүйтлийг 2 удаа хийх зардалд 1001.8 сая төгрөг зарцуулах, - Монгол Улсын Засгийн газраас бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааг түр зогсоосонтой холбоотойгоор СӨБ, ЕБС-ийн тусгай зориулалтын шилжүүлгийн зардлын хэмнэлтээс 18 хүртэлх насны бүх хүүхдэд 10000 төгрөгийг гурван сарын хугацаанд олгох шийдвэр гаргасан. Энэ дагуу Үндэсний статистикийн хорооноос авсан урьдчилсан	100%	100%	

		нарт тус тус үүрэг болгосугай.	тоон үзүүлэлтээр Монгол Улсад 18 хүртэлх насны 1,194,762 хүүхэд байгаа бөгөөд нийт 35,842.9 сая төгрөгийн зардал гарах урьдчилсан тооцоо гарч байна. Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байсан АШУҮИС-ийг БСШУС-ын сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх, үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх, байгууллагын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг шилжүүлж авах тухай 98 тоот тогтоолыг гаргасан. Энэ дагуу тус эмнэлгийн 2020 оны үйл ажиллагааны зардалд шаардлагатай 8.0 тэрбум төгрөгийг Нийслэлийн харьяа цэцэрлэгийн тусгай зориулалтын шилжүүлгийн хэмнэгдэж буй зардлаас гаргах төсвийн зохицуулалт хийх тухай БСШУС-ын сайдын 3 сарын 26-ны өдрийн 1а/1759 тоот албан бичгийг Сангийн сайдад хүргүүлсэн.			
	220	5. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн бүтэц, дүрмийг шинэчлэн баталж мөрдүүлэх, урт хугацаанд санхүүгийн тогтвортой үйл ажиллагаа явуулах бизнес төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт үүрэг болгосугай.	АШУҮИС-ийн эмнэлгийн үйл ажиллагааг хэвийн явуулах талаар арга хэмжээ авч ажиллах ажлын хэсгийг БСШУС-ын сайдын 2020 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/139 дүгээр тушаалаар байгуулан ажилласан. БСШУС-ын сайд 2020-03-20-ны өдөр тус эмнэлгийн үйл ажиллагаатай биечлэн танилцсан бөгөөд тус эмнэлгийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох болон санхүү, хөрөнгө оруулалтын асуудлыг судлан санал боловсруулах дэд ажлын хэсгийг БСШУС-ын сайдын 2020 оны А/143 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хэсгээс АШУҮИС-ийн эмнэлгийн бүтэц, дүрмийг шинэчлэн боловсруулсан.	100%	100%	

	221	6. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн төсөв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн орон тоо, төсвийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шилжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл нарт даалгасугай.	Тус эмнэлгийн 2020 оны үйл ажиллагааны зардалд шаардлагатай 8.0 тэрбум төгрөгийг Нийслэлийн харьяа цэцэрлэгийн тусгай зориулалтын шилжүүлгийн хэмнэгдэж буй зардлаас гаргах төсвийн зохицуулалт хийх тухай БСШУС-ын сайдын 3 сарын 26-ны өдрийн 1а/1759 тоот албан бичгийг Сангийн сайдад хүргүүлсэн.	100%	100%	
	222	7. Шилжиж байгаа байгууллагын үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан)-т тус тус даалгасугай.	Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх төрийн өмчийн хорооны тогтоол гараагүй байна.	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	Хугацаа болоогүй / үнэлэх боломжгүй	
	223	8. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг жил бүрийн улсын	1. БСШУС-ын сайдын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалаар “АШУҮИС-ийн эмнэлгийн санхүү, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эрчимжүүлэх үүрэг бүхий дэд ажлын дэд хэсэг”-ийг	100%	100%	

			төсөв, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл нарт тус тус даалгасугай.	байгуулсан бөгөөд дараах ажлуудыг хийлээ. Үүнд: а) БСШУС-ын сайдын багцаас 8 тэрбум төгрөгийг шийдвэрлэж, ажилчдын цалин хөлс, эм урвалж эмнэлгийн хэрэгсэл зэрэг урсгал зардлыг санхүүжүүлж байна. Мөн АШУҮИС-аас 1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус эмнэлэгт олгох асуудлыг сургуулийн удирдах зөвлөлөөр шийдүүллээ. Ингэснээр 2020.03.20-05.20-ны хооронд нийт 1 тэрбум 266 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж, 2020.03.20-ны байдлаар 437,8 сая төгрөгийн өр төлбөртэй байсныг бүрэн барагдуулсан. Мөн ажилчдын 1-3 дугаар сарын ур чадварын нэмэгдэл цалин болох 207 сая төгрөгийг шийдвэрлэж, олгуулаад байна. 2. Эрүүл мэндийн сайдын багцаас 2,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын 5 багц тендерийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Үүнд: • 1-р багц: Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийн тоног төхөөрөмж • 2-р багц: Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасгийн тоног, төхөөрөмж, багаж хэрэгсэл • 3-р багц: Дүрс оношилгооны тоног төхөөрөмж • 4-р багц: Лабораторийн тоног төхөөрөмж • 5-р багц: Ариутгал халдваргүйтгэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл Дэлхийн банкнаас 12,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын санхүүжилт өгөх шийдвэрийг гаргууллаа. Энэхүү санхүүжилтээр эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дутагдалтай байгаа тоног төхөөрөмжийн худалдан авалтыг хийж, 2020 онд багтаан бүрэн хүчин чадлаар нь тус эмнэлгийг ажиллуулах нөхцөл бололцоог бүрдүүлэхээр зорилго тавин ажиллаж байна.			
--	--	--	--	--	--	--	--

82	224	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 2020-03-22 Дугаар 2020_102	2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан боловсролын бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг энэ тогтоолын 1-д заасан хугацаанд түр зогсоож, холбогдох арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгасугай.	БСШУС-ын сайдын “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар боловсролын бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг 6 дугаар сарын 1-ний өдрөөр дуусгавар болгосон. Хичээлийн жилийн үргэлжлэх хугацааг дуусгавар болгохтой холбогдуулан теле хичээлийг 6 дугаар сарын 1 хүртэл сунгах, багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2020 оны 4-5 дугаар сард цахим хэлбэрээр зохион байгуулах шийдвэрийг уг тушаалаар гаргаж багшийн журнал тэмдэглэх заавар болон аймаг, нийслэлийн БСУГ-ын дарга нарт чиглэл өгч ажилласан.	100%	100%	
	225		4. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, ажлын байр, орон сууц болон өрөө, тасалгаанд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг улсын хэмжээнд 14 хоногийн хугацаанд багтаан зохион байгуулахыг нийт байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэдэд даалгасугай.	8 дугаар сарын 27-ны байдлаар нийт сургуулийн 67 хувь нь 1-2 удаагийн цэвэрлэгээ халдваргүйтгэлийг хийгдсэн. 9 сарын 1-ний өдөр гэхэд 3 дахь удаагийн цэвэрлэгээ халдваргүйтгэлийг бүх сургууль хийхээр төлөвлөөд ажиллаж байна. Нийт сургуулиудад суралцагчийн гар угаах нөхцөлийг нэмж бүрдүүлж байгаа ба 2160 угаалтуурыг нэмж бий болгосноор нийт угаалтуурын тоо 17279 байна. Нэг угаалтуурт ногдох хүүхдийн тоо урьдчилсан дүнгээр орон нутагт 36.9, нийслэлд 44.6 байгаа ба улсын дундаж 40.7 байна. 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт халдваргүйтгэл, ариутгалыг зохих дэглэм журмаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймаг, нийслэлийн боловсрол, соёл урлагийн	100%	100%	

				газар, нийслэлийн боловсролын газрын дарга нарт БСШУС-ын яамны ЕБГ-ын даргын 2020 оны 4/500 тоот албан бичгээр халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд ариутгал халдваргүйтгэл хийх арга хэмжээг авч ажиллахыг үүрэг болгосон. БСШУС-ын сайдын “Төлөвлөгөө удирдамж батлах тухай” А/140 дугаар тушаалаар “цэцэрлэг, ЕБС-ийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөө”, удирдамжийг баталж харьяа байгууллагын дарга нарыг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон.			
83	226	Улсын үзлэгийн мөрөөр авах зарим арга хэмжээний тухай 2020-03-25 Дугаар 2020_106	1. Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” үр дүнтэй болсныг тэмдэглэж, үзлэгийн явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авч, архив, албан хэрэг хөтлөлттэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллахыг яам, Засгийн газрын агентлаг, байгууллагын удирдлага, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Төрийн ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтөд улсын үзлэгийн мөрөөр зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 8 дүгээр сарын 24-ны “Улсын үзлэгийн мөрөөр арга хэмжээ авч ажиллах тухай” А/10 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллаж байна. Төрийн байгууллагын ажлын, ажлын зохион байгуулалт архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгийн мөрөөр зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөнд албан хэрэг хөтлөлтийн талаар зохион байгуулах 7 ажил, архивын ажлын талаар зохион байгуулах 5 ажил, Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж байгаа талаар зохион байгуулах 4 ажил болон удирдлага зохион байгуулалтын талаар зохион байгуулах 5	70%	70%	

				ажлыг төлөвлөгөөнд тусган ажиллаж байна			
	227		2. Төрийн байгууллагын архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд шаардагдах арга хэмжээг жил бүрийн батлагдсан төсвийн багцдаа багтаан санхүүжүүлж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.	Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын архивын баримт бүрдүүлэх, хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах, хадгаламжийн санг стандартын дагуу бүрдүүлэхэд 2020 онд 14'251'700 төгрөгийн хангамжийн материал авч, шаардлагатай мэргэжилтнүүдэд өгч ажилласан.	70%	70%	
	228		5. Удирдлагын академийн сургалтын хөтөлбөрт албан хэрэг хөтлөлтийн хичээлийг тусгаж хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, их, дээд сургуулиудын төгсөх ангийн оюутнуудад 2020-2021 оны хичээлийн жилээс эхлэн албан хэрэг хөтлөлтийн хичээл оруулах асуудлыг судлан шийдвэрлэж, албан хэрэг хөтлөлтийн сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг боловсруулж, мөрдүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд	Удирдлагын академи нь төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтыг урт болон богино хугацаагаар зохион байгуулж байна. Төрийн албан хаагчдад зориулсан богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрийг Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 3-т заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор баталсан. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан сургалтын хөтөлбөрийн “Хоёр. Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтын хөтөлбөр” гэсэн хэсэгт “Төрийн албан хэргийн баримт бичиг боловсруулах” гэсэн нэртэй 1 багц цаг (кредит)-ийн багтаамжтай хичээл тусгагдсан болно. 2020-2021 оны хичээлийн жилд буюу 2020 оны 9 дүгээр сараас хойш уг хичээлд нийт 236 албан хаагч хамрагдсан байна. Түүнчлэн 2021 оны төлөвлөгөөнд “Албан	70%	70%	

			Ё.Баатарбилэг нарт тус тус даалгасугай.	хэрэг хөтлөлт" хичээлийг 24 цагийн багтаамжтайгаар зайнаас цахим хэлбэрээр төрийн албан хаагчдад зориулан явуулахаар төлөвлөсөн болно.			
84	229	“Боловсролын мэдээллийн технологийн төв” байгуулах тухай 2020-03-25 Дугаар 2020_111	2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийн болон “Эрдэмнэт” сүлжээний төвийн мэдээллийн технологийн холбогдох тоног төхөөрөмж, эд хөрөнгийг “Боловсролын мэдээллийн технологийн төв”-д балансаас балансад холбогдох хууль, журмын дагуу шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (З.Мэндсайхан) нарт даалгасугай.	“Боловсролын салбарын мэдээллийн систем” болон Шинжлэх ухаан технологийн их сургуулийн дэргэдэх “Эрдэмнэт” сүлжээний төвийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг “Боловсролын мэдээллийн технологийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлэх ажлыг 2020 оны 4 дүгээр сард зохион байгуулж гүйцэтгэсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 510 дугаар тогтоолоор шилжсэн бөгөөд БШУЯ-ны хөрөнгөд бүртгэлтэй 112 нэрийн 8,553,789,503.92 төгрөгийн балансын үнэ, 2,335,513,159.36 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг "Боловсролын мэдээллийн технологийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсэн. Шинжлэх ухаан технологийн сургуулийн "Эрдэмнэт" төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 429,900.00 төгрөгийн балансын үнэ, 14,330.00 төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий компьютерын дэлгэцийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг үндэслэн "Боловсролын мэдээллийн технологийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсэн.	100%	100%	
	230		3. “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийг	“Боловсролын мэдээллийн технологийн төв” ТӨҮГ байгуулах асуудлыг Засгийн газрын	100%	100%	

			“Үндэсний дата төв”-д байршуулж, тус мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Үндэсний дата төв (М.Баттулга) нарт даалгасугай.	2020.03.25-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлэв. Тогтоолын хүрээнд тус төвийг байгуулах ажлыг хийж гүйцэтгэн 2020.06.11-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаа эхэлсэн. Тус шийдвэрийн гүйцэтгэлийг дараах байдлаар биелүүлсэн. Үүнд: “Боловсролын мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын ажиллагчдын бүтэц, орон тоо, цалин хөлсний хэмжээг батлах тухай 2020.05.08-ны өдөр БСШУС-ын сайдын тушаалаар баталсан. “Боловсролын мэдээллийн технологийн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газрыг 2020.04.23-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн гэрчилгээ авав. “Боловсролын салбарын мэдээллийн систем” болон Шинжлэх ухаан технологийн их сургуулийн дэргэдэх “Эрдэмнэт” сүлжээний төвийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, эд хөрөнгийг “Боловсролын мэдээллийн технологийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулав. “Боловсролын мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын ажиллагчдын бүтэц, орон тоо, цалин хөлсний хэмжээг батлах тухай тушаалын төслийг боловсруулан 2020.05.07-ны өдөр БСШУСЯ-ны сайдын А/222 тоот тушаалаар батлуулав. БСШУС-ын сайдын “БМТТ-ийн санхүүжилтийн зардал гаргах тухай” 2020.05.21-ний өдрийн А/252 дугаар тушаалаар “Боловсролын мэдээллийн технологийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын жилийн төсвийг баталсан. 2020 оны 2 дугаар улирлын байдлаар Үндэсний дата төвийн засвар шинэчлэлтийн ажил			
--	--	--	--	--	--	--	--

				удааширсантай холбоотойгоор Боловсролын дата төвийн тоног төхөөрөмжийг шилжүүлэх ажлыг түр зогсоогоод байна. Тухайн засварын хүрээнд манай дата төвийг ажиллуулахад шаардлагатай техникийн нөхцөл бүрдэх хүртэл шилжүүлэх боломжгүй нөхцөл үүсээд байна. Иймд улсын төсөв болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр Боловсролын салбарын дата төвд шаардлагатай сервер, стореж тоног төхөөрөмжийг шинэчлэхээр худалдан авалтыг зохион байгуулж байна. Боловсролын мэдээллийн технологийн төв боловсролын салбарын мэдээллийн системийн аюулгүй байдлыг хангаж ажиллав.			
	231		4. “Боловсролын мэдээллийн технологийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталж, үйл ажиллагааны нийт зардлыг 2020 оны батлагдсан төсвийн багцдаа багтаан хэрэгжүүлэх, цаашид шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгт даалгасугай.	“Боловсролын мэдээллийн технологийн төв” ТӨҮГ байгуулах асуудлыг Засгийн газрын 2020 оны 3 сарын 25 өдрийн 111 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлэв. “Боловсролын мэдээллийн технологийн төв” УТҮГ-ын ажиллагчдын бүтэц, орон тоо, цалин хөлсний хэмжээг батлах тухай 2020 оны 5 сарын 8 өдөр БСШУС-ын сайдын тушаалаар баталсан. БСШУС-ын сайдын “БМТТ-ийн санхүүжилтийн зардал гаргах тухай” 2020 оны 5 сарын 21-ны өдрийн А/252 дугаар тушаалаар “Боловсролын мэдээллийн технологийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын жилийн төсвийг баталсан.	100%	100%	
85	232	БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ	3.2. 3.2. Төсвийн урсгал зардлаас дараахь зардлыг	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор бүх шатны боловсролын	70%	70%	

		ШИЛЖҮҮЛСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН ЭДИЙН ЗАСГИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2020-03-27 Дугаар 2020_114	тэргүүн ээлжид санхүүжүүлэх: 3.2.1. бүх шатны эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны зардал; 3.2.2. бүх шатны төсвийн байгууллагын коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангахтай холбоотой бүх төрлийн зардал; 3.2.3. бүх шатны төсвийн байгууллагын цалин хөлс, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай зардал; 3.2.4. нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн сангийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ.	байгууллагын танхимын сургалт цахим болон зайн хэлбэрт шилжсэн. Үүнтэй холбоотойгоор их, дээд сургуулийн дотуур байрны оюутнуудыг буцаах, салбарын байгууллагуудын барилга байгууламжийг ариутгах зэрэг цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, салбарын батлагдсан төсөв болон хэмнэгдсэн эх үүсвэрээс санхүүжүүлсэн. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор төрийн албан хаагчид хэсэгчилсэн байдлаар цахим хэлбэрт шилжин ажилласан бөгөөд цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл тогтмол санхүүжиж олгогдсон. Мөн салбарын хэмжээнд тэтгэвэрт гарсан болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай тасралтгүй 5 жил ажилласан багш нарт олгох тэтгэмжийг бүрэн олгосон.			
	233		3.4. 3.4. Төсвийн урсгал зардлаас дараахь зардлын санхүүжилтийг түр зогсоох: 3.4.1. бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн	Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас 2020 оны батлагдсан төсвийн хэрэгжилтэд Засгийн газар болон Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийг хатуу баримтлан ажилласан бөгөөд үүнд нэр дурдсан гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, сургалт семинар зохион байгуулах,	100%	100%	

			авах, сургалт семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх; 3.4.2. хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал; 3.4.3. цалин хөлснөөс бусад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр; 3.4.4. бараа үйлчилгээний бусад зардал.	тавилга эд хогшил худалдан авах, урсгал засвар хийх зэрэг зардлыг санхүүжүүлээгүй. Цар тахлын үед бүх шатны боловсролын байгууллагын сургалтын үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн боловч, сургалтын үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байсантай холбоотой зайлшгүй шаардлагатай тохиолдолд боловсролын байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардал болох хичээл үйлдвэрлэлийн зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн тодорхой санхүүжилтүүд хийгдэж байна. Салбарын хэмжээнд цалин хөлсний олголт хэвийн олгогдож дууссан.			
86	234	Газар тариалангийн тогтвортой хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай 2020-04-15 Дугаар 2020_138	11. Тариалалт, ургац хураалтын ажилд төрийн албан хаагчид, оюутан, цэргийн алба хаагчдыг нэгдсэн зохион байгуулалттайгаар татан оролцуулах, тэдгээрийн ажлын хөлс, ажиллах байрны нөхцөл, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд нь хамтран хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан нарт	Хүнс Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Сайдын 01/2793 тоот, Боловсрол, Шинжлэх Ухааны Сайдын 1а/584 тоот албан бичгийн дагуу 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн хооронд ургац хураалтын компанит ажилд 1100 оюутныг хамрууллаа. Эдгээр оюутнууд Төв аймгийн Борнуур сумын Агропаркын ургац хураалт, Сэлэнгэ, Төв, Булган, Хэнтий, Дархан, Дорнод, Улаанбаатар зэрэг аймаг, хотуудад газар тариалангийн 47 компани, аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулан гар бие оролцон ажилласан.	70%	70%	

			даалгасугай.				
87	235	Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2020-04-15 Дугаар 2020_139	1. Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн танхимын сургалтын үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэл зогсоох, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт даалгасугай: 1.1. цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага, их, дээд сургууль, коллежийн суралцагчдад зориулан зохион байгуулж байгаа теле болон цахим хичээлийг 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэх; 1.2. энэ хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийг төгсөгч, 2020-2021 оны хичээлийн жилд их, дээд	БСШУС-ын сайдын “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зохицуулалт хийх тухай” 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/194 дүгээр тушаалаар боловсролын бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг 6 дугаар сарын 1-ний өдрөөр дуусгавар болгосон. Хичээлийн жилийн үргэлжлэх хугацааг дуусгавар болгохтой холбогдуулан теле хичээлийг 6 дугаар сарын 1 хүртэл сунгах, багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтыг 2020 оны 4-5 дугаар сард цахим хэлбэрээр зохион байгуулах шийдвэрийг уг тушаалаар гаргаж багшийн журнал тэмдэглэх заавар болон аймаг, нийслэлийн БСУГ-ын дарга нарт чиглэл өгөв. БСШУС-ын сайдын “Шалгалтын зохицуулалт хийх тухай” 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/118 дугаар тушаалаар ЕБС-ийн суралцагчийн 2019-2020 оны хичээлийн жилийн анги дэвших болон улсын шалгалтыг цуцалж, шалгалтын дүнг жилийн эцсийн дүнгээр тооцох, Нэгдмэл агуулга бүхий шалгалтын үнэлгээг тооцох аргачлал, хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгон ажилласан. БСШУС-ын сайд 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр “Их, дээд сургууль, коллежийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зарим зохицуулалт хийх тухай” А/195 дугаар тушаал гаргасан. Энэхүү тушаалаар: 1.2020-2021 оны хичээлийн жилд бакалаврын зэргийн хөтөлбөрт их, дээд сургууль, коллежид оюутан элсүүлэх ерөнхий	100%	100%	

			сургууль, коллежид элсэгчдээс монгол хэл бичгийн хичээлээр шалгалт авахгүй байх зохицуулалт хийх; 1.3. ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийг элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах.	шалгалтын Үндэсний хэмжээний босго оноог төрийн өмчийн их, дээд сургуульд 480, төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллежид 410, орон нутгийн их, дээд сургууль, коллежид 400 оноо байх. 2.Элсэлтийн шалгалтын босго оноог Үндэсний хэмжээнд тогтоосон босго онооноос доошгүй байхаар тогтоож Удирдах зөвлөлөөр батлуулан, оюутан суралцагчдын хяналтын тоондоо багтаан нээлттэй ил тод, цахим хэлбэрээр элсэлтийг зохион байгуулахыг их, дээд сургууль, коллежийн захирал нарт үүрэг болгосон. байна.			
88	236	Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай 2020-04-22 Дугаар 2020_144	1. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, бусад төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолууржуулах ажлыг 2020 оны III улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 144 дүгээр тогтоолын дагуу Төрийн болон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагуудыг тоолууржуулах тухай ажлын дагуу Эрчим хүчний яамнаас дараах ажлыг зохион байгуулж байна. Улсын хэмжээнд 4200 ш тоолуур суурилуулах шаардлагатай гэсэн тооцоо гарсан. Үүний дагуу 33 Төсвийн ерөнхийлөн захирагч нарт болон аймаг нийслэлийн засаг дарга нарт мэдээлэл хүргүүлсэн байна. Тухайн тогтоолоор тоолууржуулах зардлыг цахилгааны хэмнэлтийн зардлаас санхүүжүүлэхийг зөвшөөрсөн байна. Байгууллага болгон тоолуур худалдан авахад тендер зарлах тул энэ асуудлыг хялбаршуулах үүднээс Сангийн яамтай ярилцан Төрийн худалдан авах ажиллагаанаас ерөнхий гэрээ байгуулах тендер зарлана. Энэ ажлын дагуу үнэлгээний хороо байгуулагдаад 2020 оны 11 дүгээр сард ерөнхий гэрээ байгуулах 5 компани	70%	70%	

				байгуулагдаад Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт байршуулаад байна. Судалгаагаар 21 аймгийн хэмжээнд тоолууртай байгууллага байхгүй гэсэн үзүүлэлт гарсан. Одоо Коронавируст халдварын цар тахлын шалтгаалж ажил хойшлогдоод байна. Хүйтний улиралд дулаан тасалдуулж тоолуур тавих боломжгүй тул дулааны улирал эхлэхэд ажил эрчимжинэ гэж тооцож байгаа.			
89	237	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020-04-29 Дугаар 2020_151	3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан төрийн албан хаагчид нэмэгдэл, нэмэгдэл хөлс, төрийн албанаас өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах хөрөнгийг 2020 оны батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, цаашид жил бүр улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг төсвийн захирагч нарт даалгасугай.	Коронавируст халдварын цар тахлын улмаас 2020 онд хоёр удаа бүх шатны танхимыг сургалтыг цуцалж, цахим болон зайн хэлбэрт шилжүүлсэн. Үүнтэй холбоотойгоор төрийн болон орон нутгийн өмчит сургууль, цэцэрлэгийн багш ажилтнууд хэсэгчилсэн байдлаар цахим хэлбэрээр ажилласан. Холбогдох хууль журам болон тус хугацаанд гарсан Засгийн газрын шийдвэрийн дагуу төрийн албан хаагчдын нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг бүрэн олгосон. Мөн боловсролын хуулийн дагуу олгох тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, хөдөө орон нутагт тасралтгүй 5 жил ажилласан тохиолдолд олгох тэтгэмжүүдэд хамрагдахаар хянагдаж, 2020 оны төсөвт батлагдсан багш ажилтнуудыг тэтгэмжийн бүрэн олгож дууссан.	70%	70%	
90	238	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай 2020-05-06 Дугаар 2020_163	3. Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах бусад	Засгийн газрын 2019 оны 447 дугаар тогтоолоор Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны бүтэц, орон тоо шинэчлэгдсэнтэй холбогдуулан яамны ажлын байрны нэр, ангилал зэрэглэлийг Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны “Яамны	70%	70%	

			мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрт өөрчлөлтийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд үнэн зөв байдлаар оруулж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт даалгасугай.	ажлын байрны нэр, ангилал, зэрэглэл батлах тухай” Б/11 дугаар тушаалаар шинэчлэн баталлаа. “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоосон Засгийн газрын 2019 оны 472 дугаар, 2020 оны 71 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, яамны албан хаагчдын шинэ томилгоо, ангилал зэрэглэл өөрчлөгдсөнтэй холбогдуулан яамны нийт албан хаагчдын цалинг энэ оны хагас жилд 2 удаа шинэлэн тогтоосон. Төрийн албан хаагчийн цалин хөлсний мэдээллийг хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системд оруулах журам системийн шинэчлэлийг Сангийн яам хийж байгаа бөгөөд одоогоор чиглэл ирээгүй байна.			
91	239	КОРОНАВИРУС ХАЛДВАР (COVID-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД ТӨСВИЙН ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2020-05-06 Дугаар 2020_168	3. 2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулах замаар энэ тогтоолын 1 дэх заалтад заасан төсвийн зохицуулалтыг тусган баталж мөрдүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй. 3. Энэ тогтоолын 2 дахь заалтад заасан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу төрийн үйлчилгээг тасалдуулахгүй, өр, авлага үүсгэхгүй байхаар үйл ажиллагааг зохион байгуулж төсвийн сахилга	Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын байгууллагуудын 2020 оны батлагдсан төсөвт өр төлбөргүй ажиллах, хэтрэлтгүй байхад шаардлагатай санхүүжилтийн өөрчлөлтийг цаг тухайд нь боловсруулж ажилласан. Тус яамны зүгээс 2020 оны 6 дугаар сараас 12 дугаар сарыг хүртэл нийт 8 удаа Сангийн сайдад албан хүсэлт явуулан, санхүүжилтийн сар улирлын хуваарьт өөрчлөлт оруулж, санхүүжүүлэн ажилласан байна.	100%	100%	

			хариуцлагыг өндөржүүлэн ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.				
92	240	Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай 2020-05-27 Дугаар 2020_195	2. Хувьсах зардалд шаардагдах санхүүжилтийг 2020 оны батлагдсан төсвийн дүнд багтаан гаргахыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус өмчийн 157 ерөнхий боловсролын сургуулийн 46,783 хүүхдэд ногдох хувьсах зардалд нийт 18.8 тэрбум төгрөг, 529 цэцэрлэгийн 36,905 хүүхдэд ногдох хувьсах зардалд 31.4 тэрбум төгрөг батлагдсан. Төсвийн тухай хуулиар тусгай зориулалтын шилжүүлгийг сар, улирлын хуваарийн дагуу аймаг, нийслэлийн төрийн санд Сангийн яамнаас шилжүүлэн санхүүжилтийг олгодог байна.	100%	100%	
93	241	Боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2020-07-29 Дугаар 2020_32	1. Бүх шатны сургалтын байгууллагын хичээлийн жилийг 2020 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлэхтэй холбогдуулан коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарт даалгасугай.	Бүх шатны сургалтын байгууллагын хичээлийн жилийг 2020.09.01-ний өдрөөс эхлүүлэхтэй холбогдуулан “Цэцэрлэг, сургуулийн хичээл эхлүүлэх бэлтгэл хангах, зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны А/17 дугаар тушаалыг баталж хэрэгжүүлсэн байна. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийг танхимын болон танхимын бус хосолсон хэлбэрээр зохион байгуулахаар зохицуулалт хийж, хичээл, сургалтын үйл ажиллагааг сум, баг, тосгоны ерөнхий боловсролын сургууль танхимын хэлбэрээр хичээллэсэн бол аймгийн төв, нийслэлийн сургууль 3 өдөр танхимаар, 2 өдөр танхимын бус хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээг авч ажилласан байна. Танхимын сургалтыг нэг	100%	100%	

				бүлэгт 20-оос илүүгүй суралцагчтай зохион байгуулах, танхимын сургалтаар судлах хичээлийн тоог бууруулж, суралцагч өдөрт 3-4 хүртэл цаг /60 минутаар 2-3 цаг/ -ийн хичээл судлахаар зохицуулалт хийснээр 444 сургуулийн 198,2 мянган суралцагч 5 өдөр танхимаар, 388 сургуулийн 482,9 мянган суралцагч 3+2 хувилбараар тус тус хичээллэв. 2020-2021 оны хичээлийн жилийн үйл ажиллагааг Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор танхимын болон танхимын бус /цахим сургалт/ хэлбэрээр зохион байгуулах тухай Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн "Түр журам батлах тухай" А/21 дүгээр тушаалаар "Их, дээд сургууль, коллежийн хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам"-ыг баталсан. 2020 оны 11 дүгээр сарын 8-30-ны өдрүүдэд 94 их, дээд сургууль, коллежийн 91,715 суралцагчаас коронавирусын халдварт өртсөн эсэх байдлыг тодруулах 43 асуулга бүхий асуумж авч, дүнг Улсын онцгой комисст хүргүүлэн ажилласан байна. 2020 оны 12 дугаар сарын 05-08-ны өдрүүдэд 88 их, дээд сургууль, коллежийн оюутны дотуур байранд амьдарч байгаа 7839, гадуур байр хөлслөн болон ах дүү, хамаатан садныдаа амьдарч байгаа 11,360 оюутан буюу нийт 19.199 оюутныг Ковид-19 илрүүлэх шинжилгээнд хамруулсан.			
94	242	Төв, суурин газрын 2020-2021 оны	4. Монгол Улсын Зэвсэгт хүчний анги, салбарууд	Боловсрол, шинжлэх ухааны салбарт 2020 оны улсын төсвийн хөрөнгөөр 23.2 тэрбум	70%	70%	

		өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зарим арга хэмжээний тухай 2020-08-25 Дугаар 2020_69	болон боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа засварын ажлыг хугацаанд нь чанартай хийж дуусгах арга хэмжээ авахыг Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Соёлын сайд С.Чулуун, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	төгрөгийн 82 их засварын төсөл, арга хэмжээ, 10 төсөл, арга хэмжээ 2021 онд хэрэгжих дуусах, Салбарын хэмжээнд хэрэгжих сайдын багцын их засвар 11.8 тэрбум төгрөгийн 149 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр төлөвлөсөн. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 114 дүгээр тогтоолоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын их засварын 11.8 тэрбум төгрөгийг Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үйл ажиллагаанд зарцуулах шийдвэр гарсан. Засгийн газрын 114 дүгээр тогтоолтой холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс сайдын багцын их засварын төсөл арга хэмжээний гэрээ байгуулах, худалдан авах ажиллагаа зарласан төсөл арга хэмжээг зогсоож гэрээ байгуулагдсан 69 төсөл арга хэмжээг үргэлжлүүлэн их засварын ажлыг хийлгэж ажилласан. Салбарын их засварын гүйцэтгэл 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар улсын төсвийн 78, сайдын багцын 65 нийт 143 их засварын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл хийгдэж улсын комисст хүлээн авч ашиглалтад оруулсан байна.			
95	243	Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай 2020-09-14 Дугаар 2020_103	2. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлыг дотооддоо алдаагүй байгаатай холбогдуулан бүх шатны боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлэн хэвийн горимд	Бүх шатны сургалтын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг 2020 оны 9 дүгээр 21-ний өдрөөс эхлэн хэвийн горимд шилжүүлэхтэй холбогдуулан “Хичээл, сургалтын үйл ажиллагааг хэвийн горимд шилжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн А/63 дугаар тушаал батлан	70%	70%	

			шилжүүлэх, халдвараас урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Цэдэвсүрэн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан нарт даалгасугай.	хэрэгжүүлсэн. Танхимын сургалтыг эхлүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр зохицуулсан: Үүнд: 1. Цэцэрлэг, сургуулийн орчинд халдвар хамгааллын дэглэм баримтлах талаар эрүүл мэнд, онцгой байдал болон мэргэжлийн хяналтын байгууллагаас өгсөн санамж, зөвлөмжийг мөрдөх; 2. Теле хичээлийн агуулгыг бататгах, сэргээн санах хичээлийг 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн зохион байгуулах; 3. Багш, суралцагчийн дунд гарч болзошгүй айдас, түгшүүр, эргэлзээг тайлах, тайвшруулах, нийгэм-сэтгэл зүйн чиглэлээр зохион байгуулж буй нөлөөллийн үйл ажиллагааг эрчимжүүлэх; 4. Багш, ажилтан, хүүхдийг хамарсан аливаа урлаг, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулахгүй зөвхөн хичээл, сургалтад анхаарал хандуулж, хүүхэд сурлагаар хоцрохоос урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах; 5. Цэцэрлэг, сургуулийн барилгад орох, гарах боломжит бүх хаалгыг ашиглаж байгаа одоогийн зохицуулалтыг үргэлжлүүлэн мөрдөх; Их, дээд сургуулиудын хичээл сургалтын үйл ажиллагаа болон дотуур байранд амьдарч буй оюутнуудын хэвийн аюулгүй байдлыг хангах талаар тодорхой чиглэл хүргүүлэн ажилласан байна.			
